

АГУУЛГА

**НЭГ.НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	2-3
1.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР	3-6
1.3 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ЧИГЛЭЛЭЭР	6-11
1.4 ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	11-47

**ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ,
ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТООН МЭДЭЭ, ТАЙЛАН**

2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	48-54
2.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД	55-56
2.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАЛТЫН ТАЛААР	56-59

**ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

3.1 ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ	60-62
3.2 ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЛААР	63-68

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт Монгол Улсын Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, нийслэлийн иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай, чанартай, шуурхай үзүүлэх, нийслэлийн иргэд, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үндсэн зорилго, чиглэлтэй ажиллаж байна. Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага нь нутаг дэвсгэрийн байршлаар Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд нийгмийн даатгалын хэлтэстэйгээр зохион байгуулагдан нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Тус газар нь 2022 онд Нийгмийн даатгалын тухай багц хууль, Улсын их хурал болон Засгийн газрын тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал, албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр болон албан даалгаврын биелэлтийг хангахад чиглэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд болон Нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний хагас жилийн хэрэгжилт, дээд газрын тогтоол шийдвэрийн 2022 оны хагас жилийн болон жилийн эцсийн биелэлтийг Нийслэлийн нийгмийн даатгалын газрын “Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт”-ийг тус тус гарган Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох газруудад хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн “гурав”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/01 тоот тушаалаар 2022 оныг “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарлаж нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дэд төлөвлөгөө боловсруулан ажил үйлчилгээгээ уялдуулан зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолыг гаргасан бөгөөд 2022 оны 2 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа байгаа болон цэргийн албан хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 /таван зуун мянган/ төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 /дөрвөн зуун мянган/ төгрөгөөр нэмэгдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 200336 тэтгэвэр авагчийн тэтгэвэр сар 28,1 тэрбум төгрөгөөр буюу 2022 онд 309,1

тэрбум төгрөгөөр тэтгэврийн хэмжээ нэмэгдэж 2022 онд нийт тэтгэвэр авагчдад 1554,0 тэрбум төгрөгний тэтгэврийг цаг хугацаанд олгож байна.

Монгол Улсын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно гэж заасан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн хэрэгжилтийн дагуу тайлант хугацаанд 99 даатгуулагч эхэд 250,3 сая төгрөгийг олгосон байна.

ТЭТГЭВЭР АВАГЧДЫН АНХААРАЛД

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 15%-иар, бүрэн тэтгэврийн доод хэмжээг **500,000 төгрөгт**, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг **400,000 төгрөгт** хүргэн тус тус нэмэгдүүллээ.

Тэтгэврийн нэмэгдлийн жишээ: /төгрөгөөр/

Өмнө авч байсан тэтгэврийн хэмжээ	Нэмэгдэх хувь, хэмжээ	Нэмэгдсэн тэтгэврийн хэмжээ
Бүрэн тэтгэвэр		
350,000	150,000	500,000
400,000	100,000	500,000
435,000	15 хувь	500,250
600,000	15 хувь	690,000
Хувь тэнцүүлсэн тэтгэвэр		
300,000	100,000	400,000
348,000	15 хувь	400,200
500,000	15 хувь	575,000

7777 1289 | sigomongolia | www.ndaatgal.mn

Ихэр хүүхэд төрүүлсэн эхийн тэтгэмж авах хугацаа 20 хоногоор нэмэгдлээ

Тэтгэмж авах эрх үүссэн ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас **100 хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд** жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгодог боллоо.

"Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19^д дугаар зүйлийн 3 дахь хэсэг"

www.ndaatgal.mn | 7777-1289, 1800-0724 | sigomongolia

ХОЁР.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн орон тоог 433 орон тоотойгоор баталсан бөгөөд 2022 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 423 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар

№	Үзүүлэлт	Нийт тоо	Багануур	Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Нийслэл
1	Батлагдсан орон тоогоор ажиллавал зохих нийт ажилтнууд	433	20	6	63	65	23	62	58	50	61	25
	Үүнээс: Удирдлага	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
	Гүйцэтгэх ТЗ-ТҮ	374	16	5	54	60	17	52	52	43	52	23
	үйлчлэх /жолоочүйлчлэгч/	21	2	0	3	3	2	4	2	2	2	1

	Гэрээт	28	1	0	5	1	3	5	3	4	6	0
2	Одоо ажиллаж байгаа нийт ажилтнууд	423	19	6	62	67	21	62	59	49	53	25
	Үүнээс: Удирдах	10	1	1	1	1	1	1	1	1	1	1
	Гүйцэтгэх	378	16	5	57	62	15	55	54	46	45	23
	Үйлчлэх /Жолоочүйлчлэгч/	35	2		4	4	5	6	4	2	7	1
	Гэрээт											

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тус газар нь 8 зорилтын хүрээнд ажил төлөвлөж газрын даргаар батлуулаа. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд:

1. Авлигын эсрэг хуулийн дагуу жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тус газрын 29 мэдүүлэг гаргагчийн 2021 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган, ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангаар гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23,5 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилж байна. Тус газар 12 сарын байдлаар 3 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулсан.

3. Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээг тус газрын 25 албан хаагчтай гэрээг байгуулав.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, сарын мэдээ хэмнэлт хэтрэлтийн тайлбар, нийгмийн даатгалын сангуудын сарын мэдээг файл үүсгэн НДЕГ-аас олгодог санхүүжилт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын батлагдсан жилийн төсөв дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүрд нь, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг /www.shilendans.ub.gov.mn/шилэн дансны web хуудсанд цаг тухай нь байршуулан ажилласан.

5. Нийгмийн даатгалын хууль тогтоомж хэрэгжүүлэхэд иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх зорилгоор ямар үйлчилгээ авахад ямар материал бүрдүүлэх, хаана хандах зэрэг асуудлын талаар цахим хуудсаар мэдээлэх, нийтэд хамааралтай журмыг цахим хуудсанд байрлуулах, сурталчлах, таниулах арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

6. Мөн Төрийн албыг авлигаас ангид байлгах, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг мэдээллийг өргөн хүрээгээр нэмэгдүүлэх зорилгоор тус газрын албан хаагчид Авлигатай тэмцэх газрын “Авлигатай тэмцэх газар” АТГ- Олон нийтийн төв” фейсбүүк хуудсанд нэгдлээ.
7. Авлигын эсрэг ном, гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг өгсөн бөгөөд Дээрх гарын авлагуудыг тус газрын албан хаагчид болон харьяа байгууллагуудад тараан өгч Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан. Мөн сурталчилгааны зурагт хуудсыг мэдээллийг самбар болон албан хаагчдын өрөөнд нүдэнд харагдахуйц газар байршуулсан.
8. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг тухай бүрт нь хэрэгжүүлж ирсэн.
9. Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан ХАМХОМ, ХАСУМ-ийг мэдүүлэх, тайлагнах талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулсан.
10. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтад тус газрын албан хаагчдыг хамруулсан.

Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:

Тус газар нь Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 3 жилийн хугацаатай батлуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2 дэд хэсэгтэй нийт 10 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллалаа.

1. 2022 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар 24 албан хаагчдад нийт 289 137 261.18 төгрөгийн цалин, хоол унааны нэмэгдэлд 34 608 192.06 төгрөг, зэрэг дэв, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 23 албан хаагчдад 64 640 546.23 төгрөгийг тус тус олгосон.
2. Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан тус газрын 17 эмэгтэй ажилтнуудад хүндэтгэл үзүүлж нэг албан хаагчдад 150 000 төгрөгийн тэтгэмж олгосон.
3. Түлээ нүүрсний үнийн хөнгөлөлтийг тус газрын 4 албан хаагчдад олгон нийт 1 080 000 төгрөгийн тусламж олгосон байна.
4. Тус газрын бичиг хэрэг архив хариуцсан ажилтанд сар бүр 15-ны өдрийн дотор хамтын хуримтлалын фондоос 20 000 төгрөгийг үнэ бүхий сүү тараг өгөх зохион байгуулж ажиллаа.
5. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор иж бүрэн бичгийн хэрэгслээр хангаж ажилласан. Шаардлагатай бичиг хэрэгслээр тогтмол хангагдсан байна.
6. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах, хэвтэн эмчлүүлэх болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах зорилгоор гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус газрын албан хаагчид шинжилгээ оношилгоо, эмчилгээнд тогтмол хамрагддаг болсон. Мөн эрүүл мэндийн сайдын 2022 оны гуравдугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” А/139 дүгээр тушаалаар гаргасан журмын дагуу “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо”-г орон даяар эхлүүлсэнтэй холбоотойгоор тус газрын албан хаагч нар хамрагдсан.
7. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2019 20 дугаар тогтоолын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дүгээр сарын 12-ний өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай, А/641 тоот захирамжаар 94 албан хаагчдад зэрэг дэвийн шатлал ахиулж 17 албан хаагч шинээр зэрэг дэв авсан байна.

Тус Хяналт шалгалт дотоод аудит хариуцсан ахлах байцаагч О.Ууганбаатар, Ахлах нягтлан бодогч М.Цандмаа Хяналт шалгалтын байцаагч Ц.Оюунбилэг, Ц.Хандсүрэн, Нийгмийн даатгалын сангийн бүртгэл, тайлан, судалгаа хариуцсан нягтлан бодогч мэргэжилтэн Б.Ариунтуяа нар Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаа бөгөөд цалин хөлсийг олгож сурах боломжоор ханган ажиллаж байна.

Мөн хамт олноо манлайлан ажилласан Б.Солонго, И.Пүрэвжав, Э.Өрнөл нарыг Нийслэлийн нийгмийн даатгалын газрын Жуух бичиг-ээр, Нийгмийн даатгалын “Хүндэт ажилтан” тэмдгээр, Санхүү бүртгэлийн хэлтсийн Өр авлага өмч хариуцсан мэргэжилтэн Б.Санжаасүрэнг Хяналт шалгалтын байцаагч Ж.Ганзориг, Ц.Хандсүрэн Э.Сумьяасүрэн нарыг Сангийн яамны жуух бичиг-ээр Нийгмийн даатгалын сангийн тайлан судалгаа хариуцсан нягтлан бодогч мэргэжилтэн Б.Ариунтуяа, Хяналт шалгалт дотоод аудит хариуцсан ахлах байцаагч Б.Батцэрэн нарыг Сангийн яамны Санхүү банкны тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр, Ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн М.Цандмаа нар “Хөдөлмөрийн хүндэт медалиар” тус тус шагнагдсан

Ажиллагсад тохиолдсон өвчин зовлон, гачигдлыг хамт олноороо хуваалцдаг, сэтгэлийн болон эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлж, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу буцалтгүй тусламж олгож байна. Баяр ёслол, тэмдэглэлт ой, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлдэг, явган аялал, зугаалга зохион байгуулах зэргээр ажиллагсдыг ая тухтай, зөв зохистой амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахаас гадна спортын арга хэмжээнд жил бүр идэвх санаачилгатай оролцож байна.


ГУРАВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ болох www.edoc.ulaanbaatar.mn программ, дотоод удирдлагын систем болох <https://intranet.gov.mn/> дээр нийт **675** албан бичгийг дээд газраас болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдээс хүлээн аван шийдвэрлэн ажилласан байна. Үүний **129** албан бичиг нь хариутай **546** хариугүй албан бичгийг хүлээн авсан байна. Хэлтэс тус бүрээр нь авч үзвэл Тамгын хэлтсийн албан хаагчдад нийт **408** албан бичиг ирсэн бөгөөд үүнээс **101** албан бичиг хариутай, **307** хариугүй албан бичгийг хүлээн шийдвэрлэсэн ажилласан байна. Санхүү бүртгэлийн хэлтэст нийт **142** албан бичиг ирсний **15** хариутай **127** хариугүй албан бичгийг шийдвэрлэсэн байна. Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэст **125** албан бичиг ирсэн бөгөөд үүний **14** хариутай, **111** хариугүй албан бичгийг шийдвэрлэсэн байна.

Мөн тайлант хугацаанд нийт **341** албан бичгийг төлөвлөн боловсруулан явуулсан бөгөөд Тамгын хэлтэс **118**, Санхүү бүртгэлийн хэлтэс **72**, Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэс **91** албан бичгийг НДЕГ болон НЗДТГ хүргүүлэн ажилласан байна.

Е-DOC системийг ашиглан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай албан бичиг солилцох, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэн нутгийн захиргааны байгууллагуудтай тоон гарын үсгээр албан бичиг солилцон ажиллаж байна.

Өмнөх оны мөн үетэй нийт ирсэн бичгийг харьцуулан харахад:



Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр оны батлагдсантай холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам” - аа баримтлан тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсаа солин ажилласан байна.


Байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох www.intranet.gov.mn ирсэн явсан албан бичгийг хариуцсан ажилтан хаагч нарт удирдлагын цохолтын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллав.

Захирамжлалын албан бичгийг үг үсгийн болон утга найруулгын хувьд алдаатай эсэхийг шалган албан бичгийн боловсруулалтын стандартыг мөрдөж ажиллаа.

Явсан албан бичигт нэгжийн индексийн дугаар өгөн огноог тэмдэглэн төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан тоон гарын үсгээр баталгаажуулан e-doc программ ашигладаг байгууллагуудад илгээж харин тоон гарын үсэг ашигладаггүй байгууллагуудад даргын гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэн ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем <https://edoc.ulaanbaatar.mn/>-ээр болон байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох able-р албан бичгийг цахимаар илгээж цаасан суурьтайгаар илгээх албан бичгийг шуудангаар хүргүүлэн ажиллажээ.

Өмнөх оны мөн үетэй нийт ирсэн бичгийг харьцуулан харахад:



Байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох www.intranet.gov.mn ирсэн явсан албан бичгийг хариуцсан ажилтан хаагч нарт удирдлагын цохолтын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллав.

Захирамжлалын албан бичгийг үг үсгийн болон утга найруулгын хувьд алдаатай эсэхийг шалган албан бичгийн боловсруулалтын стандартыг мөрдөж ажиллаа.

Явсан албан бичигт нэгжийн индексийн дугаар өгөн огноог тэмдэглэн төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан тоон гарын үсгээр баталгаажуулан e-doc программ ашигладаг байгууллагуудад илгээж харин тоон гарын үсэг ашигладаггүй байгууллагуудад даргын гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэн ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем [/https://edoc.ulaanbaatar.mn/](https://edoc.ulaanbaatar.mn/)-ээр болон байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох able-р албан бичгийг цахимаар илгээж цаасан суурьтайгаар илгээх албан бичгийг шуудангаар хүргүүлэн ажиллажээ.

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Өргөдөл гомдол хүлээн авах онлайн программ болох smartcity.mn программ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод систем болох <https://erp.ulaanbaatar.mn/> байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох able-д өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авч, холбогдох албан хаагчдад удирдлагын заалтын дагуу шилжүүлэн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж, шийдвэрлэсэн хариуг албан бичгээр болон бусад байдлаар хүргүүлэн ажиллалаа.

Жилийн эцсийн байдлаар **232** өргөдөл гомдлыг хүлээн аван удирдлагад танилцуулан ажилласан байна. Тамгын хэлтэс **55**, Санхүү бүртгэлийн хэлтэс **2**, Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс **175** өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажилласан байна. **3** өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэх шатандаа явж байна.

Нийт шийдвэрлэсэн **229** өргөдөл гомдлын **137** буюу **59** хувийг утсаар, **50** буюу **21,5** хувийг мессежээр, **12** буюу **5,1** хувийг албан бичгээр хариу өгсөн ба **136** буюу **58,6** хувийг иргэний талд, **74** буюу **31,8** хувийг боломжгүй, **19** буюу **8,1** хувийг бусад байдлаар шийдвэрлэн иргэнд хариу өгсөн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 17 цаг 14 минут байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98,7% тай байна.

Тус тайлант хугацаанд 222 зөрчил бүртгэгдсэн бөгөөд өдөрт нь хүлээн аваагүй 86, өдөрт нь багтаан шилжүүлээгүй 82, явцын тэмдэглэл хөтлөөгүй 44, буцаалтыг 3 хоногт хийгээгүй 10 бүртгэгдсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэд, даатгуулагч албан байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл гомдлын тоо 6,4 хувиар өссөн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оноос 1 хоног 34 минутаар багассан мөн зөрчил тоон үзүүлэлт 37,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шийдвэрлэлтийн дундаж 4,3 хувиар өссөн байна.


2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ННДГ-Т ХАНДАН ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Шийдвэрлэлт					Шийдвэрлэлт
		Нийт өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Шийдвэрлэх шатандаа байгаа	
1	ННДГ	232	229	578	9	3	98,7%
	ДҮН	232	229	578	9	3	98,7%

2022 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ННДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл /агуулгаар/

№	Өргөдлийн хэлбэр	Өргөдлийн тоо
1	Талархал	3
2	Гомдол	137
3	Санал	10
4	Хүсэлт	82
	НИЙТ	232

2022 онд иргэдээс ННДГ-т хандаж ирүүлсэн өргөдөл /хандалтаар/



Нийгмийн даатгалын ерөнхий газарт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг өссөн дүнгээр улирлын сүүлчийн сарын 15-ны дотор, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт улирлын сүүлчийн сарын 30-ны дотор өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ тайланг хүргүүлж байна.

АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 01 өдрийн А/09 дүгээр тушаалаар батлагдсан хуваарь болон хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын дагуу хэлтсүүдээс үүссэн баримтыг архивд хүлээн авч үдэн хавтаслан харьяалагдах тамга тэмдгийг дарж байгууллагын архивын ажлын үндсэн зааврын хавсралт 7-д заасны дагуу хаяглан байршууллаа.

Үүссэн баримтыг байнга, түр, 70 жилийн хадгалах хугацаагаар ангилан хадгаламжийн нэгж бүрдүүллээ. Архивын данс бүртгэлийг шинэчлэн бүртгэлээ. Архивын өрөөний чийг дулааны хэмжигчээр хэмжин тэмдэглэл хийлээ. Улирал тутамд хортон шавж устгах ариутгал мөн чийгтэй цэвэрлэгээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр хийж архивын баримтын хадгалалт, хамгаалалтад болон аюулгүй байдлыг ханган ажиллаа. Албан хаагчдын албан хэрэгцээний хүсэлтийн дагуу шаардлагатай архивын баримтыг албан хэрэгцээнд түр хугацаагаар ашиглуулах бүрдээ гарын үсгийг нь зуруулан тэмдэглэл хөтөлж байна. Баримт бичгийг эх хувиас олшруулан хуулбар үнэн тамгаар баталгаажуулсан баримт бичгийг бүртгэл үйлдэн ажиллаа.

Тус газрын архив Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн 1 давхарт байсныг 3 дугаар давхар луу нүүлгэн шилжүүлэн ажилласан.



ДОТООД АЖЛЫН ТАЙЛАН

1.БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тус газар нь жил бүр “Хуримтлалын сан” уламжлалт аяныг зохион байгуулж Төрсөн өдөр нь тохиох, Хурим найр хийх, Хүндээр өвдөх зэрэгт хамт олны санлаар зарцуулдаг нь албан хаагчдын эв нэгдэл дотоод уур амьсгалыг сайжруулж бие биенээ дэмжих жаргал зовлонгоо хуваалцах эерэг бүтээлч байдлыг дэмжсэн сайхан арга хэмжээ болдог.

2022 онд байгууллагын дотоод ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.


Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, гарч болох эрсдэлээс хамгаалах үүднээс 2022 оны 01 сарын 13 -ний байдлаар 21 албан хаагч 3-р тунгийн вакциндаа хамрагдаж урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээгээ авсан бол 3-р тунгийн вакцинаа хийлгээгүй 4 албан хаагч байна.

Ковид-19 вирусээс урьдчилан сэргийлэх эрсдэлийг эрт илрүүлэх ухаалаг утсанд суурилсан “КОВИД-19 ЭРСДЭЛ” системийг нийт албан хаагчдын утсанд суулгаж байгууллагын албан ёсны фэсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллаа. Энэхүү системийг суулгаж идэвхжүүлснээр 15 минутаас дээш хамт байсан хүмүүсээс хэн нэгний PCR шинжилгээ эерэг гэсэн хариу гарахад 1-р хавьтагч гэдэг мэдээлэл утсанд нь очих бөгөөд ингэснээр халдварт өртсөн эрсдэлээ цаг алдахгүй мэдэх, эрт илрүүлэх учирч болох аливаа эрсдэлээс өөрийгөө бүрэн хамгаалах давуу талтай юм.

ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН МЭДЭЭЛЭЛ														
/2022 оны 01 дугаар сарын 11 -ний өдрийн байдлаар/														
№	Байгууллагын нэр	албан хаагчдын тоо	НИЙТ ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО									Эрүүл мэндийн эсрэг заалттай албан хаагчдын тоо	Халдвар аваад 21 хоног болоогүй байгаа албан хаагчдын тоо	Дархлаажуулалтад хамрагдахас татгалзан албан хаагчдын тоо, /шалтгаан/
			1-Р ТУН			2-Р ТУН			3-Р ТУН					
			Тухайн 7 хоногт хамрагдсан хүний тоо	нийт хамрагдсан хүний тоо	хувь	Тухайн 7 хоногт хамрагдсан хүний тоо	нийт хамрагдсан хүний тоо	хувь	Тухайн 7 хоногт хамрагдсан хүний тоо	нийт хамрагдсан хүний тоо	хувь			
1	Нийслэлийн нийгмийн даатгалын газар	25	0	25	100%	0	24	96%	1	21	84%	1	2	1
2	Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	62	0	62	100%	0	62	100%	5	31	50%	3	8	20
3	Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	20	0	19	95%	0	19	95%	1	15	75%	1	4	0
4	Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	66	65	65	100%	65	65	100%	0	63	95%	1	0	2
5	Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс	7	7	7	100%	7	7	100%	0	4	57%	1	0	2
6	Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	55	0	55	100%	0	55	100%	3	50	91%	2	3	0
7	Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	59	59	59	100%	59	59	100%		43	73%	5	10	1
8	Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	23	0	23	100%	0	23	100%	8	21	91%	2	0	0
9	Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	63	0	56	89%	0	56	89%	0	31	49%	2	2	28
10	Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс	59		52	88		52	88	8	31	53%	8	20	0
НИЙТ		439		423			422	96%	26	310	71%	26	49	54

Мөн дархлаажуулалтад Нийслэлийн хэмжээнд хэдэн албан хаагч хамрагдсан хэдэн албан хаагч Ковид-19 халдвар авсан зэрэг мэдээллийг нэгтгэн боловсруулж НДЕГ,НЗДТГазарт хүргүүлж ажиллаа.




Тэрбум мод үндэсний хөдөлгөөн НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО” хавар намрын мод тарих аян:

Монгол Улсын ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн “НОГООН ХОТ ИРГЭНИЙ ОРОЛЦОО” хаврын мод тарих аяны нээлтэд тус газрын 14 албан хаагч оролцож Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 20 ширхэг “Шар хуайс” мод бол Намрын нөхөн тарилтаар тус газрын хяналт шалгалтын байцаагч Ж.Ганзориг, Сургалт хариуцсан мэргэжилтн И.Пүрэвжав нар хамт олноо төлөөлөн 3 ширхэг агч мод суулгаж Эх байгалиа хамгаалан, эрүүл орчин бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж мод тарих, ургуулахад нэгдэхийг уриалж ажиллаа.



Цаашид тарьсан модоо арчлан хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулах бөгөөд жил бүр нэмж мод тарих ингэснээр тус газрын нэрэмжит төгөлтэй болох боломжтой юм.



Хүүхэд, ахмадууддаа хүндэтгэл үзүүлэв.

Цагаан сар, Олон улсын ахмадын баяр, Олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан Тус газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан 14 ахмадууд, тус газрын 16 албан хаагчдын 31 хүүхдүүдэд баярын бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулав.

Мөн Нийслэлийн засаг даргын гарын бэлгийг ХУД-н 19-р хорооны өндөр настан С.Дуламсүрэн, ХУД-н 15-р хорооны өндөр настан Д.Ширнэн зэрэг 5 хүнд гардуулж өгөх үүргийг хүлээж хяналт шалгалтын ахлах байцаагч О.Ууганбаатар, байцаагч Ж.Ганзориг нар гэрийн хаягаар нь хүргэж өгч гардуулж өгөв.



Илүүдэл жингүй эртэч монгол үндэсний хөдөлгөөн, Улаанбаатар Марафонд нэгдлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар улс орон даяар өрнүүлж буй “Илүүдэл жингүй Эртэч Монгол” аянд нэгдэж, хэн хэдэн кг турах вэ? 14 хоногийн болзолт уралдаан зохион байгуулж нийт 9 албан хаагч оролцож хамгийн их нь 5,6 кг бага нь 3,4 кг тус тус турж амжилттай зохион байгууллаа.

2022 оны 03 дугаар сарын 24-нд Газрын хамт олны дунд Сагсан бөмбөг, Гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан.


2022 оны 5 дугаар сарын турш хэн хэдэн км алхах, гүйх, дугуй унах вэ? болзолт уралдаанд 410 км замыг дугуйтай туулсан амжилтаар, Тамгын хэлтсийн сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, 95 км алхсан амжилтаар Тамгын хэлтсийн мэргэжилтэн Х.Заяа нар бусдыгаа тэргүүлсэн байна.

Богд ууланд алхах эвэнтийг 2022 оны 4-р сарын 09-нд зарлаж ууланд алхалт хийсэн болно.

Спортын арга хэмжээ:

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэн эрүүл мэндээ бэхжүүлэх, дадал хэвшилд сургах, биеийн тамир, спортын арга хэмжээнд гэр бүл, найз нөхөд байгууллага хамт олноороо оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар марафонд нэгдэцгээ” Нийслэлийн засаг даргын нэрэмжит цом аялах хуваарийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас хүлээн авч, Нийслэлийн нийгмийн халамжийн газарт хүлээлгэн өгсөн.

Улаанбаатар марафон-2022 арга хэмжээний 5 км гүйлтийн төрөлд тус газрын албан хаагчид амжилттай оролцлоо.



Тус газраас 2022 онд иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, авто машины зогсоолын хүрэлцээгүй байдал болон замын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах ажилтан албан хаагчдын эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, унадаг дугуйгаар ажилдаа ирэх явах боломжийг бүрдүүлэх зорилгоор

гадна талбайд унадаг дугуйн зогсоолтой болох унадаг дугуйгаар ажилдаа ирэх албан хаагчдыг дэмжиж ажиллахыг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд уриалга болгож ажиллаа.

Тус газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр батласан нэгдсэн удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ой, Нийгмийн даатгалын байгууллагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 27 жилийн ой, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ажилтны баярын өдрийг тохиолдуулан ажилтан албан хаагчдын хамтын ажиллагаа уялдаа холбоог сайжруулах, хамт олонч сэтгэлээг бий болгох, нийгмийн даатгалын салбарын хэмжээнд тамирчны хувь хүний ур чадвар авхаалж самбаа, авьяасыг тодруулах зорилготой Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын дунд Сагсан бөмбөг, Гар бөмбөг, Буудлага, Дартс, Боулинг, Теннис зэрэг спортын 6 төрөлт тэмцээн амжилттай зохион байгуулагдсан.

Тус тэмцээнд Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс хамтран оролцож Дартс, Боулингийн төрөлд багийн амжилтаар 3-р байр Хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.


Монголын үндэсний пара хөнгөн атлетикийн ууган гавьяат тамирчин ОУХМ Жамбалын Лхагважавын нэрэмжит “ДҮНЖИНГАРАВ МАРАФОН-2022” гүйлтийн тэмцээн 2022 оны 09 дүгээр сарын 25-ны ням гаригт Намрын Автомашингүй өдрөөр зохион байгуулагдаж төвийн 6 дүүрэг, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 32 албан хаагчид амжилттай оролцлоо.



Авлига ашиг сонирхлоос ангид байх олон нийтийг соён гэгээрүүлэх талаар

Тус газрын ёс зүйн зөвлөлөөс Төрийн албан хаагчийн хувьд авлига ашиг сонирхлоос ангид байх ёс зүйн зөрчилгүй ажиллахыг нийслэл дүүргийн хэмжээнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажилласан.

Авлигатай тэмцэх газрын “Авлигатай тэмцэх газар” АТГ-ын Олон нийтийн төвийн “Авлигатай тэмцэх газар Олон нийтийн төв” Фэсбүүк хуудсанд бүх албан хаагчдыг нэгдүүлэх, тус цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээ мэдээллийг Нийслэлийн нийгмийн даатгалын газар фэсбүүк, пэйж хуудсаар түгээх сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаа.



Газрын даргын тушаалаар байгуулагдсан зөвлөлүүдийн үйл ажиллагаа


Тус газрын даргын тушаалаар Ёс зүйн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөл, Спорт хамтлагийн зөвлөлүүд байгуулагдан тус бүр чиглэл чиглэлийнхээ ажлыг хариуцан зохион байгуулж хамтран ажиллаж байна.

Тус газрын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс /<https://ydc.mn>-вэбэд бүртгэлтэй/ Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах, хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх үүднээс Угийн бичгээ хөтөлдөг, хөтлөх сонирхолтой өрх, гэр бүл, иргэний судалгаанд бүх албан хаагчдаа хамруулж, Уламжлалт баасан гаригийн мэдээллийн цагаар Монголын угийн бичгийн академийн Захирал Доктор Ш.Биндэрязг урьж лекц уншуулсан нь ихээхэн сонирхолтой үр дүнтэй ажил болсон.

Газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Нэгдүгээрт шалга” аяныг дэмжин нийт албан хаагчдад удирдамжийг танилцуулж, уриалга хүргүүлж ажиллаа.



Танай хүүхдийн сургууль цэцэрлэгийн орчин хүүхдийн аюулгүй байдлыг хэр хангасан гэж үздэг вэ?
18 хариулт



Аяны хүрээнд гэр орчны аюулгүй байдлын үнэлгээг тандах google forms судалгааг /<https://forms.gle/mSpXoGqCPUTYRA8K9/> холбоосоор авч үнэлгээг хийлгэлээ.


Нийслэлийн нийгмийн даатгалын газрын биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах, шинээр цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгууллаа.

Тус газар нь Zksoftware inc Компанийн Zk Finger VX 10.0 хувилбарын 4220413250033 сери дугаартай INO1-A төхөөрөмжөөр 25 албан хаагчийн хурууны хээн өгөгдлөөр цаг ашиглалтыг

бүртгэдэг байв.

2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Хүний нөөц, хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Хяналт шалгалтын байцаагч Ж.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч 2022 оны 05 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхлэсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд уг төхөөрөмжид бүртгэлтэй хурууны хээн өгөгдлийг устгаж дээд газарт тайлагнаж ажиллаа.

Тус газар нь цаг бүртгэлийн Zk Finger брэндийн UF201 загварын төхөөрөмжийг Ай Ти Кэйр ХХК-ны <https://itcare.mn/> вэб сайтаас захиалан авч дотоод сүлжээгээр таниулан ablesoft ХХК-ын able time access програмтай холбон албан хаагчдын цаг бүртгэлийг сайжруулан газар, хэлтсийн дарга нар цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



Зураг 1: Хурууны хээн бүртгэлийг устгах үйл явц



Зураг 2: Шинэ төхөөрөмжид 24 албан хаагчийн нүүр таниулав

Албан хаагч бүрийг тоон гарын үсэгтэй болгох аяныг зохион байгууллаа.

2022 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхлэсэн цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 22 -ний өдөр Чингэлтэй дүүрэг дэхь Улсын бүртгэлийн газарт Хүсэлт гаргаж Бүх албан хаагчдаа Иргэний тоон гарын үсэгжүүлэх аяныг зохион байгууллаа. Цахим гарын үсэгтэй болсноор төрөөс авдаг бүх төрлийн цахим үйлчилгээг авах, гэрээ хэлцэл байгуулах, Банк санхүү төлбөр тооцоо, даатгал эрүүл мэндийн үйлчилгээ авах, Өргөдөл, хүсэлт, зөвшөөрөл, албан тоот болон бусад бүх төрлийн цахим сервисүүдээс үйлчилгээ авах зэрэг давуу талтай технологийн дэвшил гэдэг мэдээллийг газрын пэйж хуудас дотоод группээр сурталчилан ажиллаа.



Цаг үеийн шинжтэй бусад ажил:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигт “Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх, согтууруулах ундааны зүйл хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах” талаар тусгагдсан байна. Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Цагдаагийн байгууллагаас Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран 2022 оны 11 сарын 11-ээс 12 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “НАМАЙГ АЛГАС” нөлөөллийн аян улсын хэмжээнд зохион байгуулагдаж байна.

Хамт олон, найз нөхдийн архидалт, архи согтууруулах ундааны хэрэглээ, буруу үзэгдэл үйл явдлаас залуу үеийг татгалзуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хосууд гэр бүлдээ цаг зарцуулах, бүх нийтэд хэрэглээний ЗӨВ ХАНДЛАГА, ЗӨВ СОНГОЛТ, ШИНЭ СОЁЛЫГ ДЭМЖИХ ТӨЛӨВШҮҮЛЭХ-ийг уриалж тус аянд манай хамт олон нэгдлээ.

“Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриан дор Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нийслэлийн нийгмийн даатгалын газрын хамт олон нэгдлээ. Энэхүү аяны зорилго нь хөвгүүд эрчүүдийн оролцоог хангах замаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэж, хэзээ ч “хүчирхийлэл үйлдэхгүй, хүчирхийллийн хажуугаар чимээгүй өнгөрөхгүй” хэмээн илэрхийлдэг. Дэлхийн 180 гаруй оронд жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг дэлхий нийтээрээ нэгдмэл зорилго, нэг уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд манай улс 1991 оноос тус аянд нэгдэж, энэ жил Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, НҮБ-ын Хүн амын Сангийн дэмжлэгтэйгээр “НАНДИН БҮХНЭЭ ХАМГААЛЪЯ-ӨӨРИЙГӨӨ, ГЭР БҮЛЭЭ, ОРЧИН ТОЙРНОО” уриан дор үндэсний хэмжээнд зохион байгуулан тэмдэглэж байгаа тус аянд нэгдэж Жендерийн тухай ойлголтын талаар албан хаагчдад мэдээлэл өгч ажиллаа.

Нийслэлийн засаг дарга болон Нийслэлийн онцгой комиссын шийдвэрээр Баянзүрх дүүргийн 21, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт түүхий нүүрсний хэрэглээ, сайжруулсан түлшний нөөцлөлт, борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавих албан хаагчдын нэрс хуваарийг тус газрын даргын тушаалаар батлууллаа. Нийслэлийн нийгмийн даатгалын газрын албан хаагчид 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн Баянзүрх дүүргийн 21, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт хуваарийн дагуу дараах үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж

байна. Үүнд: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллага түүхий нүүрс хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил илэрсэн тохиолдолд тухайн хорооны Засаг даргад мэдээлэх;

Сайжруулсан шахмал түлш борлуулах цэгийн түлшний нөөц, хүрэлцээ, хангамж, картаар борлуулж буй эсэхэд хяналт тавих; Сайжруулсан түлштэй холбоотой хороодод шийдвэрлэх асуудал болон саналыг Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар /11-314876/, “Таван толгой түлш” ХХК /75005555, 70119400/, Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабт /11-324207, 11-330598/ тус тус мэдээлэх зэрэг ажлыг гүйцэтгэн цаг тухай бүрт тайлан мэдээг гарган хүргүүлж байна.



2. “80 ЖИЛ-8 БҮТЭЭЛЧ АЖИЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 80-н жилийн ойн арга хэмжээний хүрээнд “80-н жил-8 бүтээлч ажил” аяныг өрнүүлэх Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн А/152 дугаар тушаалын дагуу дэд ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. “Эрүүл орчин- эмх цэгц Ажлын байрны эрүүл ахуй, эмх цэгц, аюулгүй байдал, тохижилт, соёлжилтыг хангах.



Тус газар нь уламжлалт Баасан гаригийн мэдээллийн цагаар “Нийгмийн даатгал 80 жил-8 бүтээлч ажил” аяны хүрээнд “Баян Хүрээ” ХАБЭА-н



сургалтын төвийн Захирал, сургагч багш Х.Баянхангайг урьж “Ажлын байрны аюулгүй орчин” сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад НДЕГ, ННДГ-ын 45 албан хаагч хамрагдлаа. Тус газар нь ажлын байрны эмх цэгц, ажил хэрэгч хувцаслалт, цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор сарын аяныг зарлаж явц байдлыг 7 хоног бүр үнэлгээний хуудсаар дүгнэн ажиллаа.



АЖЛЫН БАЙРНЫ ЭМХ ЦЭГЦ, ЦАГ АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ТАМГЫН ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Д.д	Албан хаагчдын нэрс	Цаг бүртгэл, ажлын цаг ашиглалт					Харилцааны соёл, сахилга хариуцлага					Ажлын байрны эмх цэгц					Ажил хэрэгч хувцаслалтын байдал					НИЙТ ДҮН
		2022.10.21	2022.10.28	2022.11.04	2022.11.11	2022.11.18	2022.11.25	2022.10.21	2022.10.28	2022.11.04	2022.11.11	2022.11.18	2022.11.25	2022.10.21	2022.10.28	2022.11.04	2022.11.11	2022.11.18	2022.11.25			
1	Л.Гэрэлмаа																					
2	Б.Солонго																					
3	И.Пүрэвжав																					
4	Б.Мөнхгэрэл																					

Үнэлгээ өгсөн: Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн дарга/Л.Очирбал/

ЖИЧ: 7 Хоног бүрийн Баасан гаригт тухайн ажлын 5 өдрийн нийлбэр үнэлгээг нэгтгэж дүгнэнэ.

Үнэлгээ: 1-5 оноотой байх бөгөөд сарын сүүлд хангалттай сайн албан хаагчдыг шалгаруулна.

Цаг бүртгэлийн мэдээг able time програмаас өдөрөөр, 7 хоногоор, сараар харах боломжтой

№	Огноо	Цагууд		Хоц	Илүү	Цагууд		Хоц	Илүү	Төлөв
		Ирсэн	Явсан	-ролт	цаг	Ирсэн	Явсан	-ролт	цаг	
				(мин)	(мин)			(мин)	(мин)	
1	22/11/28 - Даваа	7:27:07	20:50:13	0	262	7:23:57	17:17:19	0	53	
2	22/11/30 - Лхагва	6:58:34	17:14:11	0	75	6:35:20	17:05:41	0	89	
3	22/12/01 - Пүрэв	7:32:15	17:00:47	0	27	6:53:28	17:06:46	0	72	
4	22/12/02 - Баасан	7:23:37	17:01:01	0	37	6:44:25	17:22:01	0	97	
5	22/12/05 - Даваа	7:36:34	17:45:15	0	68	6:37:23	17:02:59	0	84	
6	22/12/06 - Мягмар	7:22:24	17:00:17	0	37	6:44:02	18:02:59	0	75	
7	22/12/07 - Лхагва	7:41:07	17:00:54	0	18	7:21:41	17:00:23	0	38	
8	22/12/08 - Пүрэв	7:47:32	17:01:05	0	13	7:37:16	17:00:23	0	22	
9	22/12/09 - Баасан	7:53:14	17:00:53	0	6	7:42:36	[?]	0	17	Нүүрсэнд явсан
12	22/12/12 - Даваа	7:32:37	17:00:05	0	27	7:20:32	17:00:01	0	39	
				0	570			0	586	

Ажлын цаг ашиглалтын сүүлийн 7 хоногийн мэдээгээр Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн Хяналт шалгалтын байцаагч Ж.Ганзориг, Санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Сумьяасүрэн нар хамгийн өндөр үзүүлэлт үзүүлж хамт олноо манлайлсан байна.


Ажлын байрны эмх цэгц Өрөө тасалгааны цэцэгжүүлэлтийг 1 цонхон дээр 3 цэцэг байхаар төлөвлөн зохион байгуулж ажилтан албан хаагчид өрөө тасалгаандаа их цэвэрлэгээ хийж, компьютер тоног төхөөрөмжийн залгуур тог цахилгааны мантож зэргийг утас далдлагч ашиглан эмх цэгцтэй зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдын хэрэглэдэг UB ERP, <https://intranet.gov.mn>, зэрэг дотоод үйл ажиллагаанд хэрэглэдэг програмуудын хэрэглээг нэмэгдүүлж Нийт албан хаагчдад танилцуулах албан бичгийг тойрч гарын үсэг зуруулдаг байдлыг бүрэн халж <https://padlet.com> оруулдаг болсон. ингэсээр цаг зав, цаас хэмнэж байна. Мөн Цахим орчинд ажиллах албан хаагчдын мэдлэг мэдээлэл дээшлэх давуу талыг бий болгож байна.



Хоёр. “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлээ”

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид дагаж мөрдвөл зохих ажил хэрэгч хувцаслалтын талаар болон Улсын байцаагчийн шалгалтад шалгуулагчдад зориулж <https://padlet.com>, <https://www.flipsnack.com>, <https://prezi.com>, <https://www.mentimeter.com> гэх мэт цахим орчны боломжуудын талаар мэдээлэл зөвлөгөө бэлтгэн дотоод групп, чатад байршуулсан бөгөөд Улсын байцаагчийн шалгалттай холбоотой мэдээллийг нэгтгэн шалгалт өгөх албан хаагчид хэрэгтэй мэдээллээ нэг дороос авах цахим боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Албан хаагч нэг өдрийн чөлөө болон тодорхой цаг минутаар чөлөөг авах, хүндэтгэх үзэх шалтгааны улмаас цаг бүртгэлийн төхөөрөмжид цагаа бүртгүүлээгүй тохиолдолд Тамгын хэлтэст ирүүлсэн чөлөөний хуудсыг үндэслэн able time access програмад төлвийг оруулан газар, хэлтсийн дарга нар цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



My presentations

+ New presentation + New folder

Q Type to search

Name	Owner	Modified
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА ISLIDE VOICE	me	Jun 24, 2022
сэтгэл ханамжийн судалгаа-2 ISLIDE	me	Jun 24, 2022

Цахим орчны ашиглан ажлын бүтээмжээ талаар онлайн сургалт фэйсбүүк группэд албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх ажиллаж байгаа бөгөөд хаагчдаас сэтгэл ханамжийн <https://www.mentimeter.com> дамжуулан авч нэгтгэж




боломжуудыг нэмэгдүүлэх бэлтгэн дотоод байршуулан технологийн зорилго тавин нийт албан судалгааг вэб сайтаар танилцлаа.

Гурав. “Нэг зорилго- Нэг хамт олон”

Хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, бие биедээ урам өгөх зорилгоор “АЖИЛ ХЭРЭГЧ ӨГЛӨӨНИЙ ЦАЙ” “Талархалын аян” “Өглөөний дасгал” зэрэг арга хэмжээг НДЕГ-тай хамтран зохион байгуулж Тамгын хэлтсийн мэргэжилтэн Б.Солонго, Санхүү бүртгэлийн хэлтэс Э.Сумьяасүрэн, Хяналт шалгалтын ахлах байцаагч Б.Батцэрэн нарт хамгийн олон талархлын захидал ирсэн бол, Хууль эрх зүй, хүний нөөцийн мэргэжилтэн Л.Гэрэлмаа, Хяналт шалгалтын байцаагч Д.Базарбаатар нар хамгийн олон санал сэтгэгдэл захидал бичсэн албан хаагчаар шалгарлаа.

Ажил хэрэгч өглөөний цай арга хэмжээг Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс зохион байгуулан нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах аяны хүрээнд тус газраас дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст томилогдон ажиллаж байгаа багууд удирдамжийн дагуу хийж хэрэгжүүлж байгаа ажлынхаа явцын мэдээллийг удирдлагуудад танилцуулж,

санал солилцов. Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, Хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хариуцан Өглөөний дасгал арга хэмжээг зохион байгуулсан ажиллаж цаашид ажлын байрны дасгал хөдөлгөөнийг уламжлал болгон зохион байгуулж байхаар төлөвлөн ажиллаж байна.



Дөрөв. “Сэтгэлийн бэлэг”

НДЕГ-ын ЭХМТК- оос хариуцан зохион байгуулсан “Дусал цус-дүүрэн амьдрал” аянд нэгдэж цус өгөх хориглосон заалтыг баримтлан тус газрын 8 албан хаагч цусаа хандивлалаа.

“Ид шид бүтээцгээе” уриан дор нэгдэж зорилтот бүлгийн хүүхдүүдэд сэтгэлийн дэм үзүүлэх, ирээдүй болсон бяцхан дүү нартаа инээд хөөр, баяр баясал, итгэл найдвар төрүүлж мэдлэгээр хөрөнгө оруулах ажлыг НДЕГ, ННДГ-ын ажилтан албан хаагч нарыг хамруулан 2022 оны 10 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хандивын үйл ажиллагаанд Тамгын хэлтсийн мэргэжилтэн Б.Солонго, Б.Мөнхгэрэл, Хяналт шалгалтын байцаагч Д.Оюунтуяа нар бусдыгаа манлайлан оролцлоо.



Хандиваар цугларсан Ном, сурах бичиг, хичээлийн хэрэгсэлийг 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр <https://www.facebook.com/adrfmongol> “Хүүхдийн Оюуны Боловсролыг дэмжих төв”-ийн номын санд хүлээлгэн өгсөн байна.

Тав. “Маркетинг, түншлэл хамтын ажиллагаа”

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон, газрын фэсбүүк хуудас, youtube сувагт тавигдсан мэдээ мэдээллийг шэйрлэх түгээх шэйрлэсэн хэсгийг дэлгэцийн зургаар баталгаажуулан сургалт хариуцсан мэргэжилтэнд ирүүлдэг байхыг уриалга болгон ажиллаж байна. Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны 250 албан хаагчдад Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч сонирхсон асуултуудад хариулт өгч хамтран ажиллаа.



<https://nndg.ndaatgal.mn> вэб сайтын хөгжүүлэлтийн 2 удаагийн сургалтад сургалт, сурталчилгаа, мэдээллийн технологи дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав хамрагдаж тус газрын вэбийн шинэчлэлт хөтлөлтийг сайжруулан Баганхангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Вэб хуудасны анхан шатны шинэчлэлтийг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Сургалт олон нийт, хамтын ажиллагааны газрын даргын 2022.10.21-ний өдрийн 08/1948 тоот албан бичгийн дагуу болон “80 жил-8 бүтээлч ажил” аяны хүрээнд Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах, хамралтыг нэмэгдүүлэх, иргэдэд нийгмийн даатгалд хамрагдах сэдлийг төрүүлэх агуулга бүхий уриа үг зохиох уралдаанд ирүүлсэн бүтээл уриа үгийг СОНХАГ-т хүргүүлж ажиллаа.

Зургаа. “Мэдлэгээ хуваалца”

Нийгмийн даатгалын ерөнхий газраас бэлтгэн гаргасан Нийгмийн даатгалын холбогдолтой дүрэм, журам, аргачлал, заавар, зөвлөмжийн эмхэтгэлийг нийт албан хаагчдад танилцуулж qr кодоор дамжуулан хэрхэн мэдээлэл авах QR код үүсгэх арга аргачлалын талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулан ажиллаж Хувь хүний хөгжлийн төвшингөө ахиулах зорилгоор харилцан бие биеээсээ суралцах туршлага судлах хөдөлгөөн өрнүүлж “Номоо солилцоё” арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.



НДЕГ-аас баталсан Нийгмийн даатгалын үйлчилгээний тухай мэдээлэл агуулсан QR Код бүхий нэрийн хуудсыг крилл монгол бичгийн хосолсон хэлбэрээр бэлэн загвар авч хэвлүүлэн албан хэрэгцээнд болон хувийн зориулалтаар ашиглахыг санал болгож уриалж ажиллаа.

Өр авлага бууруулах ажилтай уялдуулан хариуцаж буй дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтсийн орлогын байцаагч нартай туршлага, мэдээлэл солилцох ажлыг үр дүнтэй ажил хэрэгч байдлаар зохион байгуулан ажиллаж байна. НДЕГ, ННДГ-ын бүсгүйчүүдэд зориулан Тус газрын эцэг эхийн зөвлөлөөс санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр “МИНИЙ ТООДОН БАРИУВЧНЫ ТҮҮХ, ТҮҮНИЙГ УРЛАХУЙ” номын зохиогч Боловсрол судлалын ухааны доктор О.Өнөрмааг урьж Өөрийн биеийн хэмжээг зөв авч “Дээл эсгэх” аргачлалын талаар, мөн монголчуудын уламжлалт товч шилбэ зангидах /бороо/ аргын талаар мэдээлэл зөвлөгөө өгч идэвхтэй оролцсон албан хаагчдад “Миний тоодон бариувчны түүх, түүнийг урлахуй” номоор урамшууллаа. Энэхүү арга хэмжээ нь албан хаагчдад сонирхолтой үр өгөөжтэй хэрэгтэй сургалт болсон талаар бүсгүйчүүд ам сайтай байлаа.



Долоо. “Хамт даа хөгжье”

Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээний “80 жил-8 бүтээлч ажил” аяны удирдамжийн 7.1-д заасан “Ажилтан албан хаагчид сайн туршлага хуваалцах” ажил болон “Нийгмийн даатгалын байцаагчийн нэг өдөр” туршлага солилцох арга хэмжээний хүрээнд Газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын байцаагч нар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст сэлгэн ажиллаа.

Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст сэлгэн ажилласан хуваар

№	Сэлгэн ажиллах албан хаагчийн овог нэр	Сэлгэн ажиллах албан хаагчийн албан тушаал	Ажиллах дүүрэг	Ажиллах ажлын байр
1.	О.Ууганбаатар	Хяналт, шалгалтын ахлах байцаагч	СХДНДХ	Тэтгэврийн хяналт
2.	Б.Батцэрэн	Хяналт, шалгалтын ахлах байцаагч	БЗДНДХ	Тэтгэврийн хяналт
3.	Д.Оюунтуяа	Хяналт, шалгалтын байцаагч	СБДНДХ	Тэтгэврийн хяналт
4.	Ц.Оюунбилэг	Хяналт, шалгалтын байцаагч	ЧДНДХ	Тэтгэврийн хяналт
5.	Ж.Ганзориг	Хяналт шалгалтын байцаагч	БЗДНДХ	Тэтгэврийн хяналт

6.	Б.Цэрэнчимэд	Хяналт шалгалтын байцаагч	БГДНДХ	Тэтгэврийн хяналт
7.	Э.Болормаа	Хяналт шалгалтын байцаагч	ХУДНДХ	Тэтгэврийн хяналт
8.	Ц.Хандсүрэн	Хяналт шалгалтын байцаагч	ЧДНДХ	Тэтгэврийн хяналт
9.	Д.Базарбаатар	Хяналт шалгалтын байцаагч	БГДНДХ	Тэтгэврийн хяналт
10.	Н.Алтантуяа	Хяналт шалгалтын байцаагч	ХУДНДХ	Тэтгэврийн хяналт

ХШДАХ-ийн хяналт шалгалтын байцаагч нар батлагдсан удирдамжийн дагуу Санхүү бүртгэлийн хэлтэстэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст шимтгэлийн авлага барагдуулах аян зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд сэлгэн ажиллах удирдамж хуваарь батлагдсаны дагуу 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг шалгаж, арга зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлж ажиллаа.

Тэтгэврийн хяналтын ажил нь дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн бүтэц, тасгийн зохион байгуулалтын онцлогоос хамаарч ХШДАТ болон Үйлчилгээний тасагт харъяалагдаж байгаатай холбоотойгоор тус 2 тасагтай хамтарч ажилласан бөгөөд нэг хяналт шалгалтын байцаагч дунджаар тэтгэвэр тогтоолтын байцаагчаас орж ирсэн 8-10 тэтгэврийн тогтоолтын үндэслэл, хувийн хэргийн бүрдүүлэлтийг шалгасан.

Сэлгэн ажиллах хугацаанд нийт 103 тэтгэврийн үндэслэлийг шалгаж баталгаажуулсан бөгөөд 23 тэтгэврийг баримтын бүрдэл дутуу, ажилласан жил буруу оруулсан шалтгаанаар тогтоолтын байцаагчид буцааж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад чиглэсэн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Тэтгэврийн үндэслэлийг хянаж баталгаажуулах ажлын хажуугаар тэтгэврийн байцаагч нарын банкууд руу илгээдэг тэтгэвэр олголтын файл бэлтгэж байгаа байдалтай танилцаж, санал солилцож ажиллаа.

Сэлгэн ажиллах явцдаа тухайн ажлын байранд заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, албан харилцааны соёлыг мөрдөж, харилцааны болон ажлын алдаа дутагдал гаргалгүй сайн туршлагаа хуваалцаж ажилласан болно.

Тус газраас НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт судалгааны газартай хамтран Монгол Улсад нийгмийн даатгалын байгууллага үүсэж, хөгжсөний түүхт 80 жилийн ойн баярын үйл ажиллагааны хүрээнд нийгмийн даатгалын байгууллагад удирдах алба хашиж байсан ахмад үе, өнөөдөр ажиллаж байгаа дунд үе, шинээр нийгмийн даатгалын байгууллагын ажилтан болсон залуу үеийн төлөөллийг оролцуулсан “ХАМТДАА ХӨГЖЬЕ” сэдэвтэй 3 үеийн уулзалтыг зохион байгууллаа.

Энэхүү уулзалт-хэлэлцүүлэгт НДЕГ-ын анхны дарга, УИХ-ын гишүүн асан, Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч Ц.Сүхбаатар, НДЕГ-ын Дэд дарга бөгөөд ННДГ-ын анхны дарга асан Ч.Сумаахүү, НДЕГ-ын Хяналт, үнэлгээний газрын дарга асан Ё.Пүрэвцэрэн, НДЕГ-ын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн дарга асан Ц.Дашдондог, ЧДНДХ-ийн болон ННДГ-ын хэлтсийн дарга асан Ч.Солонго нарын ахмад үеийн төлөөлөл уригдан оролцов.

Дунд үеийн төлөөлөл болж НДЕГ-ын Хяналт, шалгалтын гарын Улсын ахлах байцаагч Б.Батсуурь, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн М.Бямбадулам, ННДГ-ын

Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, БЗД-ийн НДХ-ийн Үйлчилгээний тасгийн дарга Д.Гэрэлцэцэг, ХУД-ийн НДХ-ийн Тэтгэврийн хяналтын байцаагч Ж.Сүхбаатар нар уригдан оролцлоо.

Залуу үеийг төлөөлж НДЕГ, ННДГ, нийслэлийн 6 дүүргийн НДХ-ийн залуу ажилтнууд оролцон ахмад, дунд үеийн төлөөлөгчдийн туршлага, дурсамжийг сонсож, өнөөдрийн шинэ ололт амжилтаа ярилцаж, сургаал захиасыг нь хүртсэн халуун дулаан уулзалт боллоо.




Найм. “Байгаль орчноо хайрлая”

Тус газрын хамт олон Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 2021 оны намар, 2022 оны хавар, намар дараалан мод тарьсан бөгөөд цаашид тарьсан модоо арчилж тордох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү ажилд дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийг татан оролцуулж Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын нэрэмжит төгөл бий болгохыг зорин ажиллаж байна. Нийслэл дэхь нийгмийн даатгалын байгууллагууд хамтран “80 жил-8 бүтээлж ажил” аяныхаа хүрээнд туул голын эрэг орчим, усны нөөцийн сав газарт үүссэн хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид идэвхтэй оролцлоо.

Энэхүү ажилд нийт 350 гаруй албан хаагчид оролцож, 3 км газраас 600 орчим шуудай хог хаягдлыг цэвэрлэлээ / <https://nndg.ndaatgal.mn/>

Найм. “Байгаль



Хуруу зайг бид маш зүйлд хэрэглэж дуусмагц нь хогийн савандаа хаячихдаг. Гэтэл зай нь өөртөө кадми, хар тугалга, мөнгөн ус, лити, зэрэг хортой элемент металл өөртөө агуулдаг бөгөөд байгаль хүний биед сөрөг нөлөө үзүүлдэг учраас жирийн нэг хогтой адилтган үзэж цуг хаяж болохгүй зүйл юм.

Иймээс хаягдал зайг цуглуулах хайрцаг бүтээх, хаягдал зайг цуглуулахын ач холбогдолын талаар нийт албан хаагчдад уриалга, танилцуулга мэдээлэл хүргэн ажиллаа.

Бид хаягдал зайг цуглуулах хайрцагаа дүүрэхээр Засгийн газрын ордны зүүн талд байрлах city tower-ын 12 давхарт байрлах Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны 1204 тоотод тушаах юм.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ, ЭРХ СЭРГЭЭХ, ЭРХ БАТАЛГААЖУУЛАХ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”-ын дагуу нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Нийслэлийн хэмжээнд 191, Орон нутагт 252 байцаагч албан хаагчид хамрагдаж ерөнхий мэдлэгийн сорил, онол аргазүйн бодлого, Монгол бичиг, албан хэрэг хөтлөлт гэсэн 3 чиглэлээр шалгуулж мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө.


Шалгалгуулагчдын компьютерийн үйлдлийн систем, дотоод сүлжээ, техник хангамж шалгалтын програмын серверийн аюулгүй байдал зэргийг Мэдээлэл технологийн төвийн мэргэжилтэн Н.Лхагважав, Баянгол, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн мэдээлэлийн технологийн мэргэжилтнүүд хамтран зохион байгуулж шалгалтын комисс болон шалгуулагчдыг цай кофегоор дайлах, анги танхим ширээ сандал бэлтгэх бичиг хэргийн материалаар хангах зэрэг зохион байгуулалтыг Нийслэлийн нийгмийн даатгалын газрын албан хаагчид зохион байгуулан ажиллаа.



3. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН:

3.1 Ажилтан, албан хаагчдад чиглэсэн дотоод сургалтууд:

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн системийн шинэчлэгдсэн хувилбарын танилцуулга: 2022 оны 01 сард Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын систем” шинэчлэгдэн шинэ хувилбар нэвтэрч буйтай холбогдуулан цалингийн систем, Төрийн албан хаагчдын мэдээллийг шинэчлэх, баяжилтыг хийх цуврал цахим сургалтуудад сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Хүний нөөц хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, нар тухай бүр хамрагдлаа. Сургалтын үр дүнд: <https://hrm.csc.gov.mn> сайтад албан хаагчдын мэдээллийг бүрэн гүйцэт оруулж, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилган ТАЦН системд цалин татагдах нөхцөлийг бүрдүүлж мэдээллийн ямар нэгэн алдаагүй боллоо.



Байгууллагын нууц, Хувь хүний нууц, ХАСХОМ гаргах талаар:

2022 оны 01 сард зохион байгуулагдсан тус сургалтад Хэлтсийн дарга нар, Ахлах мэргэжилтнүүд, Хүний нөөцийн мэргэжилтэн, Хяналт шалгалтын байцаагч нар хамрагдлаа.


Төрийн албан хаагчийн ёс зүй, Аз жаргалтай ажиллахын нууц вэб сургалт:

2022.01.07-28- хооронд Төрийн албаны зөвлөлийн <https://csc.gov.mn/b/70> вэб сайтын “Бодлогын иноваци Вебинар” хэсэгт байршуулсан мэдлэг олгох цахим сургалтуудын файлыг байгууллагын дотоод сүлжээ, фэсбүүк хуудсаар түгээж албан хаагчдаар судлуулах ажлыг зохион байгуулж Тус газрын ёс зүйн зөвлөл хяналт тавьж ажиллаа.



Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

Сургалт сурталчилгаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн сургагч багш Л.Ариунболдтой хамтран тус газрын 25 албан хаагчид болон Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” түүнд нийцүүлэн байгууллагын дотоод журам шинэчлэн батлах тухай цахим сургалтыг 2022 оны 02 сарын 09-нд цахимаар зохион байгууллаа.



Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ


Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ, цахим сургалтад Хяналт шалгалтын ахлах байцаагч Б.Батцэрэн, Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, И.Пүрэвжав нар хамрагдлаа.



Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлага ёс зүйн зөвлөлийн сургалт:

Тус газрын ёс зүйн зөвлөл, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамтран 2022 оны 03 дугаар сарын 11-нд Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлага сэдэвт танхимын сургалтыг зохион байгууллаа.


Сургалтаар Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай үндсэн ойлголт, ёс зүйн зөрчлийн талаарх ойлголтуудын талаар товч мэдээлэл өгч, Хүний нөөц хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа 4 төрлийн бодит кэйс дээр тулгуурлан шийдвэрлэлтийн талаар анхаарах асуудлыг онцлон тайлбарлалаа.



Тэтгэвэр, Тэтгэмж хариуцсан байцаагч нарт зориулсан сургалт: Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн 17 албан хаагч НДЕГ-аас зохион байгуулсан тэтгэвэр, тэтгэмж тогтооход анхаарах асуудал, цахим тэтгэмжийн талаарх сургалтад хамрагдаж Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгалаа.



Үнэт зүйлд суурилсан төрийн албан хаагчийн ёс зүй

Нийгмийн даатгалын ерөнхий газар Төрийн албаны зөвлөлөөс 2022 оны 04 сарын 07-нд зохион байгуулсан тус сургалтад Ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүд, сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамрагдлаа.



Өргөдөл гомдол хариуцсан ажилтнуудын сургалт Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт

Архивын ерөнхий газар болон Нийслэлийн засаг даргын тамгын газраас Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын архив бичиг хэргийн ажилтнуудад зориулсан Танхимын болон цахим 2 удаагийн сургалта Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл хамрагдаж Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамтран бусад албан хаагчдаа цахимаар болон танхимаар мэдээлэл өгч Албан хэрэг хөтлөлтийн EDoc системийн хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллаа.



Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслийн сургалт

Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол улсад мэргэжлийн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх” нь төслийн сургалт хэлэлцүүлэг Уламжлалт Пүрэв гаригийн сургалтуудад Хүний нөөц, хуул эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа нар тогтмол хамрагдлаа.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Зорилт: Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих.

Оролцогч: Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүд, ажлын албаны албан хаагчид; Улсын Их Хурлаас удирдлага нь томилогдог байгууллагуудын албан хаагчид.

Төрийн албаны зөвлөлийн яам, агентлаг, аймаг, нийслэл дэх салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, албан хаагчид; Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга нар, бусад албан хаагчид.

Хугацаа: 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 10:00-11:10 цаг

Хэлбэр: Цахим /вебинар/
 ZOoM meeting ID: 820 9228 6594
 Passcode: 123456

Чиглүүлэгч: Ж.Эрдэнэбат –Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн мэдээлэн сангийн газрын дарга


Хугацаа	Үйл ажиллагаа	Нэр	Албан тушаал
10:00-11:00	Гүйцэтгэл сайжруулах сургалтын хөтөлбөр	А.Даваасүрэн	Дэвж, баримт сургалтын төвийн гүйцэтгэх захирал, эрхлэх сургагч багш
11:00-11:07	Асуулт, заруулт		
11:07-11:10	Хяналт	Ц.Амартөгс	Төрийн албаны зөвлөлийн гишүүн


МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ



Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн сэдэвчилсэн сургалтууд /Сар бүр/

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд захиалгат сургалтыг цахимаар болон танхимаар сар бүр зохион байгуулдаг бөгөөд оны эхэнд хамрагдах сургалтын нэр, албан хаагчдын тоон мэдээллээ явуулсан бөгөөд 2022 оны 2-6 дугаар сард Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын түүх, бүтэц чиг үүрэг, ERP Системийн хэрэглээ, Сургалт хүний нөөцийн мэргэжилтнүүдийг чадваржуулах, Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн манлайлал, Төрийн байгууллагад нийтлэг хөтөлөгддөг баримт бичгийг боловсруулах арга зүй зэрэг сэдэвт сургалтуудад албан хаагчдыг жигд оролцоотой хамруулахыг зорин ажиллаж байна. Тайлант хугацаанд 14 удаагийн сургалтад **23** албан хаагч хамрагдлаа.




НИЙСЛЭЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАТЛАМЖ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв нь төрийн албан хаагчдын ур чадварыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх, төрийн үйлчилгээнд шинэ соёл, стандартыг нэвтрүүлэх, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоход чиглэсэн богино хугацааны сургалтуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар зохион байгуулдаг.

"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж НХНХТ-өөс зохион байгуулж буй төлөвлөгөөт сургалтуудад албан хаагчдыг хамруулж хариуцлагатай ажиллаж буй танай байгууллагад баяр хүргэж ажлын байранд сургалт зохион байгуулах ЭРХ олгов.

НИЙСЛЭЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Баасан гаригийн сургалт мэдээллийн цаг

Уламжлалт баасан гаригийн мэдээллийн цагаар Тус газрын Залуучуудын зөвлөлөөс санаачлан Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах, хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх үүднээс Угийн бичгээ



хөтөлдөг, хөтлөх сонирхолтой өрх, гэр бүл, иргэний судалгаанд бүх албан хаагчдаа хамруулж, Монголын угийн бичгийн академийн Захирал Доктор Ш.Биндэряг урьж Угийн бичиг, Удмын сангийн тухай, Угийн бичиг хөтлөх арга зүй, хөтлөхийн ач холбогдол зэрэг сонирхолтой мэдлэг мэдээлэл сонслоо.


Шинэ ажилтныг мэргэшүүлэх цахим сургалт:



Нийгмийн даатгалын ерөнхий газраас салбарын хэмжээнд 2020, 2021 онуудад шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан шинэ ажилтны цахим болон танхимын сургалтад Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав хамрагдаж нийгмийн хамгааллын тогтолцоо, Нийгмийн даатгалын байгууллагын түүхэн замнал, үнэт зүйлс, харилцаа хандлагын талаар мэдлэг мэдээлэл авч сургалтын гэрчилгээ авсан.

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III /2020-2024/-ын хэрэгжилтийг ханган ажиллах зорилтын хүрээнд НДЕГ-аас МУИС-ын профессор Г.Буянтогтох багштай хамтран зохион



байгуулсан цахим сургалтад тус газрын Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Х.Заяа, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамрагдаж цахим гэрчилгээ авсан.

Алсын хараа 2050

Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13-ний өдрийн 52-р тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг танилцуулах богино хугацааны цахим сургалтыг Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институт, Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв хамтран үе шаттай зохион байгуулж байна.

2021 онд Санхүү бүртгэлийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн ахлах нягтлан бодогч М.Цандмаа хамрагдаж гэрчилгээ авсан бол энэ онд Газрын дарга Г.Болорсүх, Тамгын хэлтсийн Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Б.Ариунтуяа нар хамрагдаж шалгалтаа өгч гэрчилгээ авсан.



Нийслэлийн богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нь” сэдэвт сургалт

Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс Улс нийслэлийн урт, дунд, хугацааны бодлоготой уялдуулан “Нийслэлийн богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нь” сэдэвт сургалт хэлэлцүүлэгт Тус газрын Бодлогын хэрэгжилт тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Х.Заяа оролцлоо.



НДЕГ-ын захиалгат сургалт: НДЕГ болон “Апдэйт Пи Ар” ХХК-тай хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ур чадвар-манлайлал”, “Хэрэглэгчийн сэтгэл зүй”, “Төрийн албан хаагчийн имиж, ажилтны хэв шинжит дүр” сэдэвт сургалтад 2022 оны 6 сарын 20, 29-ний өдрүүдэд тус газрын 10 гаруй албан хаагч хамрагдлаа.



Хилийн цэгийн анги, тусгай салбаруудын санхүү, бүртгэл тооцоо, хүний нөөц, үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын байгууллагын алба хаагчдын бүсийн сургалт



Сангийн яам, Үндэсний аудитын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мандах Их сургууль хамтран зохион байгуулсан 40 цагийн багц сургалтад Тус газрын Хяналт шалгалтын байцаагч Д.Базарбаатар, Д.Оюунтуяа нар хамрагдаж Сертификат авсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн танилцуулга сургалт:

2022 оны 06 сарын 17-ны өдөр Сангийн яам, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар хамтран НЗД-ын хэрэгжүүлэгч агентлагуудын санхүүгийн ажилтнуудад зориулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн танилцуулга цахим сургалтад Ахлах нягтлан бодогч-Ахлах мэргэжилтэн М.Цандмаа оролцлоо.

ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАНИЛЦУУЛГА
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

09:50-10:00	Цахимгаар холбогдох /TEAMS/	Оролцогчид
10:00-10:05	Нээлт	Сангийн яам
10:05-10:25	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга	Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Балзуул
10:25-10:40	Асуулт, харуулт, санал	Сангийн яам

Дараах QR кодыг гар утаснаас уншуулж бүртгүүлэх, мөн цахим /teams/-р холбогдохыг урьж байна

БҮРТГЭЛ

<https://forms.office.com/ku69ahM1GmV>

2022-06-17 Баасан гариг 10:00 – 10:40

Цахим /TEAMS/

267416, 80185028

ЦАХИМГААР ХОЛБОГДОХ /TEAMS/

shorturl.at/kcX1

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн 8-р сарын сургалт:

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг сэдэвчилсэн сургалтуудын 8 сарын хуваарийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 17-нд “Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь” сэдэвт цахим сургалтад Тамгын хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхгэрэл, Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Б.Ариунтуяа, Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн Хяналт шалгалтын байцаагч Э.Өрнөл нарыг хамруулж дотооддоо цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх хичээл бэлтгэн газрын дотоод пэйж хуудсанд байршуулж ажиллаа.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах, хадгалах эрх бүхий албан хаагчдын нэгдсэн сургалт:

Нийслэлийн засаг даргын тамгын газраас 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан уг сургалтад, Тус газрын эрх бүхий албан тушаалтан Хүний нөөц, хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа оролцлоо.



“Стресс менежмент”

Нийслэлийн засаг даргын тамгын газрын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулагддаг танхим болон цахим сургалтуудад хагас жилийн идэвх санаачилгатай хамгийн олон албан хаагчийг хамруулсан тул танхимаар ажлын байран дээрээ сургалт авах эрх үүссэний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 21-нд “Стресс менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 19 албан хаагч хамрагдлаа. Тус сургалтыг Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, сургагч багш Т.Оюундарь нар хөтлөн явуулж албан хаагчдад ажлын байран дээрх стрессийн шалтгаан үр дагаварын талаар тайлбарлаж, стрессээ удирдах үр чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхүйц олон сонирхолтой тест кэйс дээр ажиллуулж, google gmail цахим хаягийн хөтлөлт болон түүний боломжуудын талаар мэдээлэл зөвлөгөө өглөө.



№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал	Хуви		Нэгэн ажиллаж			Гарын зөвшөөрч авсан эхэл	Утасны дугаар	Гарын үсэг	Цэг бүртгэл	
				Эр	Эн	18-25	26-45	46-55					55-аас дээш
0	1		3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Г.Болорсук		Дарга										
2	О.Баянтэмүүл		Хөгжлийн дарга										
3	С.Ундармаа		Самуу бүртгэлийн хэлтсийн дарга										
4	Л.Очирын		Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга										
5	Х.Зана		Бодлогын ажлаар, тогтоолт шийдвэрлэл, Бюджет, зарцуулалтын ажлаар										
6	И.Луринсан		Сургалт сурталчлага, мэдээлэл технологийн, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн										
7	Б.Минигэрийн		Бичиг, ярих, арван хариуцсан ажилтан										
8	Э.Сумъяасурэн		Нэгжид хариуцсан байгууллагын бүртгэл, хяналт, судалгаа хариуцсан мэргэжилтэн, үйл ажиллагааны хяналтын байрны										
9	В.Сонгоо		Өр ажилга хариуцсан мэргэжилтэн										
10	М.Буяндалар		Өр ажилга хариуцсан мэргэжилтэн										
11	Б.Санжасурэн	Нийслэлийн Дэдтөрийн Ерөнхий газар	Өр ажилга, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн										
12	О.Урианбаатар		Хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан ажил байцаагч										
13	Б.Балдрын		Хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан ажил байцаагч										
14	Э.Болормаа		Хяналт шалгалтын байцаагч										
15	Н.Алтантүвшин		Хяналт шалгалтын байцаагч										
16	Ж.Гагариэл		Хяналт шалгалтын байцаагч										
17	Д.Вазарбаяр		Хяналт шалгалтын байцаагч										
18	Б.Цэрэнчимэл		Хяналт шалгалтын байцаагч										
19	Д.Оюунтүвшин		Хяналт шалгалтын байцаагч										
20	Ц.Снурбаатар		Хяналт шалгалтын байцаагч										
21	Э.Өрхид		Хяналт шалгалтын байцаагч										
22	Ц.Хангалзан		Хяналт шалгалтын байцаагч										

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн 10-р сарын сургалт:

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг сургалтын 10 дугаар сарын хуваарын дагуу Сургагч багш Ч.Отгонцэцэгийн хөтлөн явуулдаг “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт сургалтад 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Тамгын хэлтсийн мэргэжилтэн Б.Солонго хамрагдлаа.



Авлигатай тэмцэх газрын цахим сургалт:

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр АТГ-аас зохион байгуулсан “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтад тус газрын 12 албан хаагч хамрагдлаа.


“Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавх бэхжүүлэх”

Нийслэлийн засаг даргын 2022 оны А/1106 захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд байгууллагын мэдээ тайлан хариуцсан албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор зохион байгуулсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавх бэхжүүлэх” сэдэвт сургалтад Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч О.Ууганбаатар, Тамгын хэлтсийн мэргэжилтэн Б.Солонго нар хамрагдлаа.



Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх сургалт:

2022 оны 10 дугаар сарын 30-с 11 дүгээр сарын 10-ны хооронд Удирдлагын академи-с зохион байгуулдаг Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх цахим сургалтад Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн Хяналт шалгалтын байцаагч Э.Өрнөл хамрагдаж онлайн сертификат авсан болно.



Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтад шалгуулагчид зориулсан сургалт:

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 21 аймаг 9-н дүүргийн сургалт хариуцсан мэргэжилтнүүдэд <https://surgalt.ndaatgal.mn/#/login> вэбийн танилцуулга сургалт болон Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтад шалгуулагчид зориулсан цахим сургалтад тус газрын Сургалт хариуцсан мэргэжилтэн болон шалгалт өгөх албан хаагчид идэвхтэй хамрагдлаа.

Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сургалт:

Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл”- ийн гишүүдийг чадваржуулах сургалтад тус газрын Эцэг эхийн зөвлөлийн нарийн бичиг Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав хамрагдлаа Сургалтаар Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт мэдлэгийг олж авлаа.



“Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн дүн шинжилгээний практик ур чадварыг бэхжүүлэх нь”

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны Байгууллага (JICA) Хүнийг хөгжлийн газар, Дээд боловсрол, нийгмийн хамгааллын групп Нийгмийн хамгааллын баг хамтарсан Монгол Улсын “Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн дүн шинжилгээний практик ур чадварыг бэхжүүлэх нь” онлайн сургалтад Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга С.Ундармаа, Ахлах нягтлан бодогч-Ахлах мэргэжилтэн М.Цандмаа нар 2022 оны 10-р сарын 24-26, 11-р сарын 16-ны өдрийг дуусталх хугацаанд үе шаттай хамрагдлаа.с

Тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, семинар:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Европын холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан “TAIEX-INTRA Түншлэлийн арга хэрэгслийн хүрээнд үндэсний тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх семинар”-т хяналт шалгалтын 3 байцаагч 2022 оны 09 дүгээр сарын 12-14 ний өдрүүдэд оролцов.

Төрийн албаны пүрэв гаригийн сургалтууд:

Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гаригт зохион байгуулдаг цахим сургалтуудад нийт албан хаагчдыг идэвхтэй хамрагдахыг уриалж ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Монголын тусгаар тогтнолын үнэ цэнэ” сэдэвт сургалтад Тамгын хэлтэс сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав оролцлоо.

Баасан гаригийн мэдээллийн цаг:

14 хоногт нэг удаа болдог “Баасан гаригийн мэдээллийн цаг” хөтөлбөрөөр “Баян Хүрээ” ХАБЭА-н сургалтын төвийн Захирал, сургагч багш Х.Баянхангайг урьж Ажлын байрны аюулгүй орчин сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад НДЕГ, ННДГ-ын 45 албан хаагч хамрагдлаа.




Удирдлагын академийн магистрын сургалт:

Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургуулийн Төрийн удирдлагын магистрын зэрэг горилж Хяналт шалгалтын байцаагч Ц.Хандсүрэн, Санхүү бүртгэлийн хэлтсийн Сангийн тайлан бүртгэл хариуцсан мэргэжилтэн нягтлан бодогч Б.Ариунтуяа Мөн удирдахуйн ухааны сургуулийн Төрийн захиргааны менежмент магистрын гарагийн сургалтад Хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч О.Ууганбаатар, хяналт шалгалтын байцаагч Ц.Оюунбилэг нар хамрагдаж байгаа бөгөөд цалин хөлсийг олгож сурах боломжоор ханган ажиллаж байна.

3.2 ИРГЭД ДААТГУУЛАГЧ, АЖИЛ ОЛГОГЧ НАРТ ЧИГЛЭСЭН СУРГАЛТУУД

Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ:

2022 оны 01 сарын 07-ний өдөр Хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамтран Улаанбаатар төмөр замын худалдан авалт борлуулалтын албаны 25 ажилчдад сургалт зохион байгуулж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.




Цэ энд цэ ХХК:

Худалдаа, тээврийн үйлчилгээ үзүүлэгч ЦЭ ЭНД ЦЭ ХХК-ын 96 ажилтан албан хаагчдад Нийгмийн даатгалын тухай мэдлэг олгох сургалт зохион байгууллаа.

Сургалтаар тус байгууллагын ажилчдад Нийгмийн даатгалын ач холбогдол, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж хуульд шинээр орсон өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өглөө.


Сургалтад оролцогчид Нийгмийн даатгалд даатгуулсанаар ямар төрлийн үйлчилгээг авах боломжтой талаар дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөөг тодорхой бодит жишээ кэйс дээр тулгуурлан тайлбарлаж өгөхийг илүүтэй сонирхож асуулт асууж байв.



Нийслэлийн газрын албаны газар зохион байгуулалтын албаны албан хаагчдад зориулсан сургалт:

Тус газрын Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн Хяналт шалгалтын байцаагч Б.Цэрэнчимэд, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны 250 албан

хаагчдад Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сургалт зохион байгуулж, сонирхсон асуултуудад хариулж мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.



3.4 ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ

Монголын хуульчдын холбооны нэрэмжит нээлттэй хаалганы өдөрлөг:

Монголын хуульчдын холбоо нь нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн Про Боно өдөр” буюу хуульчийн нийтэд тустай үйл ажиллагаа үзүүлэх өдөрлөг болгон жил бүр зохион байгуулдаг бөгөөд тус өдөрлөгийн арга хэмжээнд батлагдсан хуваарийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтнүүд иргэд даатгуулагчдад шууд үзүүлэх боломжтой төрийн үйлчилгээг үзүүлж, нийгмийн даатгалын хууль болон цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага тараах материал тарааж иргэдийн сонирхсон асуултад тайлбар зөвлөгөө өгч ажиллаа.

Өдөрлөгийн үеэр нийт **134** иргэн, даатгуулагчийн нийгмийн даатгалын хууль, тогтоомжтой холбоотой асуултад хариулт, зөвлөгөө өгч ажилласан. Иргэдийн тавьсан асуудлыг төрлөөр ангилбал:

№	Газар, хэлтэс	Тэтгэвэр тэтгэмж	Сайн дурын даатгал	Нийгмийн даатгалын шимтгэл	Цэргийн тэтгэвэр тогтоолтын талаар санал	Гар утасны аппликэйшн баталгаажуулсан
1	Нийгмийн даатгалын газар, хэлтэс	65	19	43	1	6
НИЙТ		134				



“Автомашингүй өдөр”- 2022 арга хэмжээний хүрээнд нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын зохион байгуулсан ажлын тайлан:

“Автомашингүй өдөр-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Нийслэлийн засаг даргын 2022 оны А/1206 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд цогц үйлчилгээг нэг дороос үзүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг таниулах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа.

Тус өдөрлөгт Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Сүхбаатар, Хан-Уул, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд оролцож Сүхбаатарын талбай болон Улсын их дэлгүүрийн гадна талбайд иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Өдөрлөгийн үеэр нийт 357 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалтай холбоотой хууль тогтоомжийн зөвлөгөө мэдээлэл өгч, 17 иргэнд сайн дурын даатгалын болон “нийгмийн даатгал” гар утасны аппликэйшнийг баталгаажуулах үйлчилгээ үзүүлж ажилласан.



Олон улсын ахмадын өдөрт зориулан нэгдсэн өдөрлөгийн тайла:

Монголын Ахмадын холбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран Монгол Улсад ахмадын байгууллага үүсч хөгжсөний 90, 91 жилийн ой, Олон улсын ахмадын өдөрт зориулсан өдөрлөгийг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан.

Тус өдөрлөгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагууд, Монголын ахмадын холбоо, нийслэл, дүүргийн ахмадын хороод, аж ахуй нэгж байгууллагын ахмадын хороо, зөвлөл, Геронтологийн үндэсний төв зэрэг 20 орчим байгууллагууд оролцож, ахмад настуудад төрөл бүрийн үйлчилгээ үзүүлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, тус яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч Ц.Сүхбаатар, дэд ерөнхийлөгч П.Бямбацэрэн нар ахмад настуудын бүтээлтэй танилцаж, талархал илэрхийлж, амжилт хүсэв.

Өдөрлөгт Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн **8** байцаагч нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж, нийт **113** иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын Тэтгэврийн даатгал хариуцсан мэргэжилтэн М.Бямбадулам “Нийгмийн даатгалын байгууллагын танилцуулга”, “Тэтгэврийн даатгал” сэдвээр өдөрлөгт оролцогчдод мэдээлэл хийсэн.

Өдөрлөгт ажилласан албан хаагчдын нэрс



№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Ажиллах цаг
1	Ц.Жаргалсайхан	ЧД НДХ-н тэтгэврийн байцаагч	88089660	09:00-12:00
2	М.Энхмаа	ЧД НДХ-н сангийн нягтлан бодогч	99031508	
3	Бат-Эрдэнэ Баянжаргал	БЗД НДХ-н тэтгэврийн хяналтын байцаагч	80676081	
4	Дамдинсүрэн Норовсүрэн	БЗД НДХ-н Орлого шимтгэлийн байцаагч	96920120	
5	Б.Хишигсайхан	ЧД НДХ-н хяналт шалтгалтын байцаагч	94494556	12:00-16:00
6	С.Доржпагам	ЧД НДХ-н Орлого шимтгэлийн байцаагч	99992001	
7	Жамсран Цэрэннадмид	БЗД НДХ-н Эрүүл мэнд, СДД-н байцаагч	99292383	
8	Отгонтоогооч Түвшинбаяр	БЗД НДХ-н Эрүүл мэнд, СДД-н байцаагч	90119655	
9	О.Байгалмаа	Нийслэлийн нийгмийн даатгалын газрын тамгын хэлтсийн дарга	99116779	08:00-16:30
10	Т.Цэцэн	СОНХАГ-ын ахлах мэргэжилтэн	99718899	
11	Ч.Номинтуяа	Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн	99034951	
12	Ч.Сансарчимэг	СОНХАГ-ын мэргэжилтэн	99065556	
13	И.Пүрэвжав	ННДГ-ыг сургалт хариуцсан мэргэжилтэн	88063348	

3.5 ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ЦАХИМ СҮЛЖЭЭ АШИГЛАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ ТАЛААР

Цаг үеийн холбогдолтой постер мэдээллийг түгээх, дамжуулах:

Олон нийт мэдээллийн хэрэгсэл, сайт, page хуудсаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг сурталчлах ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь <https://nndg.ndaatgal.mn/> албан ёсны вэб сайт болон “Нийслэлийн нийгмийн даатгалын газар” фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан ХНХЯ, НДЕГ- аас бэлтгэн гаргасан **68 удаагийн** пост мэдээг шинээр оруулах болон түгээж дамжуулж чат, болон комментоор иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл тогтмол өгч ажиллаа.

Иргэдийн эрхзүйн боловсрол-Хотын соёл пэйж хуудастай хамтран Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан ажиллаж байна. Иргэдийн эрхзүйн боловсрол-Хотын соёл пэйж хуудсанд Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний гарын авлага, Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл агуулсан QR Код бүхий картыг байршуулан ажиллаа.

Нийслэлийн засаг даргын тамгын газрын Ulaanbaatar.mn вэбэд сар бүрийн вэб мэдээг байршуулах, болон нийгмийн даатгалын үйлчилгээний тухай мэдээлэл агуулсан QR код бүхий постерийг байршуулан ажиллаа. Төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлага MNS6285:2017 стандартыг баримтлан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/108 дугаар тушаалаар “ndaatgal.mn” цахим хуудсыг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд зөвхөн <http://www.ndaatgal.mn> вэбсайтад холбогдсон холбоосоор дамжин салбарын хэмжээнд нэгдсэн чиглэлийн дагуу хөтлөж ажиллуулах үүрэг өгөгдсөн. Тус газар нь энэхүү үүрэг даалгаврын дагуу <https://nndg.ndaatgal.mn/> вэб сайтын хөгжүүлэлтийг шинэчлэн хөтлөж мэдээлэл оруулах, шинэчлэх ажлыг цаг тухай бүр хийж хэрэгжүүлж вэб хөгжүүлэлт хариуцсан ажилтан Мэдээлэл технологи, сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжавыг Вэб сайт хөгжүүлэлтийн хоёр удаагийн сургалтад хамруулсан. Мөн Нийслэлийн нийгмийн даатгалын газар youtube суваг ажиллуулж нийгмийн даатгалын үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэн эргэх холбоотой ажиллаж байна.

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ 4 ДҮГЭЭР
УЛИРЛЫН ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ /тэрбум төгрөгөөр/

Нийгмийн даатгалын
сангийн орлого

1 843.0

Нийгмийн даатгалын
сангийн зарлага

1 525.8



1 512.1

160.6

138.3

32.0



1 360.7

103.8

17.8

43.6



Ажил
олгогчийн тоо
36405



Албан журмын
даатгуулагчийн
тоо
745114



Сайн дурын
даатгуулагчийн
тоо
71706



Өндөр настны
тэтгэвэр
153492

Тахир дутуугийн
тэтгэвэр
24360

Тэжээгчээ
алдсаны тэтгэвэр
7640

Цэргийн
тэтгэвэр
12994

ҮОМШӨ-ний ТД,
ТА тэтгэвэр
1850




ХЧТА тэтгэмж авагчид
92519

Жирэмсэн амаржсаны
тэтгэмж авагчид
30557



Оршуулгын
тэтгэмж авагчид
5898

Ажилгүйдлын
тэтгэмж авагчид
18318

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020-2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААРХ ОРЛОГО ЗАРЛАГА



Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого 1843,0 тэрбум төгрөг, зарлага 1525,8 тэрбум төгрөг зарцуулсныг өмнөх онтой харьцуулж үзэхэд орлого 250,3 тэрбум төгрөгөөр буюу 15,7 хувиар өссөн бөгөөд зарлага 328,4 тэрбум төгрөгөөр буюу 31,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар өндөр нас, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 198486 иргэдийн тэтгэвэрт 1 360,7 тэрбум төгрөг зарцуулж, нийт тэтгэвэр авагч иргэдийн тоог өмнөх онтой харьцуулж үзэхэд 9789 тэтгэвэр авагч буюу 5,2 хувиар, зарцуулсан хөрөнгө нь 289.3 тэрбум төгрөг буюу 30,7 хувиар тус тус өссөн байна.

Тэтгэврийн төрөл	2020 оны 4-р улирал		2021 оны 4-р улирал		2022 оны 4-р улирал	
	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/
Өндөр насны	139 094	685 925.6	145 006	733 919,84	153 492	1 044 914,4
Тахир дутуугийн	24 546	85 349.2	24 011	85 724,52	24 360	132 061,7
Тэжээгчээ алдсаны	7 091	25 762.9	7 298	26 340,26	7 640	39 913,2
Цэргийн	12 125	89 779.0	12 382	94 874,04	12 994	136 426,7
Нийт	182 856	886 816.7	188 697	940 858,66	198 486	1 353 316,0



ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэмжийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 128974 даатгуулагчдад 103,8 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов.Тэтгэмжийн даатгал 542,4 сая төгрөг буюу 0,5 хувиар өссөн байна.

Тэтгэмжийн төрөл	2020 оны 4-р улирал		2021 оны 4-р улирал		2022 оны 4-р улирал	
	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	63 151	12 828,1	102 890	19 399,3	92 519	19 861,6
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	33 563	69 063,8	34 701	74 566,6	30 557	73 157,8
Оршуулгын тэтгэмж	5 068	5 509,3	7010	7 611,0	5 898	7 873,8
Дүн	101 782	87 401,4	144 601	101 576,9	128 974	100 893,2

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулсан хөрөнгө / тэрбум төгрөгөөр/




ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



2022 оны жилийн эцсийн байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 1850 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 14,411.4 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 678 даатгуулагчийн тэтгэмжид 717,6 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон рашаан сувиллын зардалд 981,8 сая төгрөг зарцуулсан байна. Зардал өмнөх оны мөн үеийнхээс 3,061.3 сая төгрөгөөр өссөн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сан	2020 оны 4-р улирал		2021 оны 4-р улирал		2022 оны 4-р улирал	
	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/
Тахир дутуугийн тэтгэвэр	1 774	11 470.4	1 730	11 289.7	1 666	13002.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	194	1 234.1	188	1 219.8	184	1 408.5
Тэтгэмж төлбөрийн	502	494.7	344	407.5	678	717.6
Рашаан сувиллын зардал	721	248.2	253	131.7	651	981.8
Дүн	3 191	13 447.4	2 515	13 048.7	3 179	16 110.0

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ҮОМШӨ-НИЙ 2020-2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ОРЛОГО ЗАРЛАГА




АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



2022 оны жилийн эцсийн байдлаар ажилгүйдлийн даатгалын сангаас 18318 даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид 43.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо урьд оноос 2866 даатгуулагчаар өсч, зардал нь 4.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Ажилгүйдлийн даатгалын сан	2020 оны 4-р улирал		2021 оны 4-р улирал		2022 оны 4-р улирал	
	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/	Даатгуулагчийн тоо	Зарцуулсан Хөрөнгө /сая төгрөг/
Ажилгүйдлийн тэтгэмж	12 569	35 006,4	15 452	39 184,7	18 318	43 550,2
Дүн	12 569	35 006,4	15 452	39 184,7	18 318	43 550,2

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО ЗАРЛАГА



Нийслэлийн хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2020-2022 оны 4-р улирлын байдлаар харьцуулан харуулбал

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	2020 оны 4-р улирал	2021 оны 4-р улирал	2022 оны 4-р улирал
		157,86	247,07
Дүн	157,86	247,07	308,0


Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага урьд оноос 60,9 тэрбум төгрөгөөр буюу 24,6 хувиар өссөн байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг дүүргээр нь харуулвал:

Дүүргүүдийн нэр	2021 оны 4-р улирал	2022 оны 4-р улирал	Зөрүү	Өсөлт бууралтын (%)
Чингэлтэй	25 346,31	33,624.71	+8,278.40	+32,7
Сонгинохайрхан	19 353,34	26,342.39	+6,989.05	+36,1
Баянгол	32 487,84	42,882.56	+10,394.72	+32,0
Хан-Уул	51 805,94	65,454.49	+13,648.55	+26,3
Баянзүрх	43 021,23	53,407.56	+10,386.33	+24,1
Сүхбаатар	62 792,15	71,340.74	+8,548.59	+13,6
Багануур	11 401,94	13,846.04	+2,444.10	+21,4
Налайх	615,27	762.33	+147.06	+23,9
Багахангай	246,23	300.89	+54.66	+22,2
Дүн	247 070,25	307,961,70	+60,891.46	+24,6

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг өмнөх оныг мөн үетэй харьцуулан дүүрэг тус бүрээр нь үзэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдүүлсэн Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд байна. Дэлхий даяар тархаж буй COVID-19 тахалын улмаас 2020, 2021 оны эдийн засгийн байдал бүхэлдээ хүндэрч аж ахуй нэгж байгууллагийн үйл ажиллагаа доголдож, үйл ажиллагаагаа зогсоож орлого буурч 2022 онд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдсэн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдсэн байна.

2022 оны жилийн эцийн байдлаар авлагын насжилтыг хувиар болон тэрбум төгрөгөөр харуулбал.



Авлагын насжилт	Авлагын дүн (тэрбум. төгрөг)
0-30 хоног	25,7
31-60 хоног	26,8
61-90 хоног	28,5
91-120 хоног	26,5
121-ээс дээш	200,2
Нийт	308,0

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг насжилтаар нь харуулвал 65,0 хувь буюу 207,5 тэрбум төгрөгийг 121 хоногоос дээш авлага, 10,0 хувь буюу 29,6 тэрбум төгрөгийг 61-90 хоногтой авлага хамгийн өндөр хувийг эзэлж байна.

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ 12 САРЫН МЭДЭЭНИЙ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Үйл ажиллагааны урсгал санхүүжилтын орлого

/ сая.төг/




Нийгмийн даатгалын сангаас урсгал санхүүжилт нийт 8 476.4 сая төгрөг байгаагаас цалин хөлс болон нэмэгдэл 6 281.9 сая төгрөг буюу 74%, ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл 809.6 сая төгрөг буюу 10%, бусад санхүүжилтийн орлого 1 384.9 сая төгрөг буюу 16%-г тус тус эзлэж байна.

Үйл ажиллагааны урсгал санхүүжилтын зарлага/ сая.төг/



Нийт зардлын дүн 7 742.3 сая төгрөг байгаагаас цалин хөлс нэмэгдэл 6 281.9 төгрөг буюу 81%, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 809.6 сая төгрөг буюу 11%, бусад зардал 650.8 сая төгрөг буюу 8%-ийг тус тус эзлэж байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын 2020-2022 оны 4-р улирлын байдлаарх бүтэц, орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл



2022 оны 4 дүгээр улирлын хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын орон тоон төлөвлөгөө 433 байгаагаас гүйцэтгэл нь 425 буюу 8 орон тоо хэмнэж ажилласан байна.

Хоёр. Санхүүгийн тайлан, мэдээ гаргалтын талаар

Нийслэлийн дүүргүүдийн нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн болон үйл ажиллагааны, нэгтгэсэн санхүү, төсвийн гүйцэтгэлийн 2022 оны 4 дүгээр улирлын тайлан гаргах бэлтгэл ажлыг хангуулж, мэргэжил арга зүйгээр ханган, тайлан гаргахад анхаарах асуудал, тайлан ирүүлэх хуваарийг гарган ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн дагуу Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны 1,2,3 дугаар улирлын тайланг тогтоосон хугацаанд тойрох хуудасны хамт цаасаар болон файлаар хүлээн авч шалган нэгтгэж, нэгдсэн тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны 1,2,3 дугаар улирлын тайланг тогтоосон хугацаанд тойрох хуудасны хамт цаасаар болон файлаар хүлээн авч шалган нэгтгэж, үнэн зөв нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг сар бүрийн 5-ны дотор файлаар хүлээн авч шалган нэгтгэж, нэгтгэсэн мэдээг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

Санхүүгийн тооцоолох төвийн “Plastic” програм, Сангийн яамны Э-Тайлан, Мэдээллийн технологийн төвийн NegtgelUND програмуудаар нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2021 оны жилийн эцэс, 2022 оны 1,2,3 дугаар улирлын тайланг тогтоосон хугацаанд тойрох хуудасны хамт цаасаар болон файлаар хүлээн авч шалган нэгтгэж, үнэн зөв нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т, 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан “Мэдээлэл аудит” ХХК-д хуулийн дагуу хүргүүлж зөрчилгүй стандарт дүгнэлт авч ажилласан.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл, сангийн авлага, өглөгийн 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1-11 дүгээр

сарын мэдээнүүдийг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн мэдээнүүд, холбогдох судалгааг Нийслэлийн статистикийн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт сар бүрийн 5-ны дотор хүргүүлэн ажиллаа.

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь сар бүр 3-н төрлийн мэдээг жилд 36 удаа хүлээн авч нэгтгэсэн байна. Тайлангийн хувьд улирал тутамд 6 төрлийн тайланг хүлээн авч, жилд 24 төрлийн тайланг 4 удаа дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс хүлээн авч нягтлан шалгаж, нэгтгэн дээд шатны байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын бүтэц орон тоо, норм нормативыг шинэчлэн тухай холбоотой тоон мэдээ судалгааг (нийт ажил олгогч, албан журмын даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо сайн дурын даатгуулагчийн тоо, эрүүл мэндийн даатгалд хамрагдсдын тоо, хүн амын тоо) сүүлийн 3 жилийн байдлаар гарган газрын удирдлагад танилцуулсан.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан дүн шинжилгээ хийж сар бүр цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, сарын мэдээ хэмнэлт хэтрэлтийн тайлбар, нийгмийн даатгалын сангуудын сарын мэдээг файл үүсгэн НДЕГ-аас олгодог санхүүжилт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын батлагдсан жилийн төсөв дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүрт нь, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг www.shilendans.ub.gov.mn/шилэн дансны web хуудсанд цаг тухай нь байршуулан ажилласан.

Нийслэл дэх төрийн аудитын газраас Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцсэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гэж **“Зөрчилгүй”** стандарт дүгнэлт авч ажилласан. Мөн 2021 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын захиалгаар “Мэдээлэл аудит” ХХК аудит хийж, зөвлөмж ирүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг цаг хугацаанд нь гарган хүргүүлэн ажилласан.

“Мэдээлэл аудит” ХХК-аас ирүүлсэн Аудитын гэрчилгээ, аудитын дуусгавар болгосон тухай тайлан, менежментийн захидал, аудитын байгууллагад хүргүүлсэн менежментийн захидлын хариуны хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

2022 оны 10 дугаар сарын 17-оос 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийг дуусталх хугацаанд Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын баталсан №01 дүгээр удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, дүрэм журам зааврын хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудал нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, хэлтсийн удирдлага, байцаагч ажилтнуудад чиглэл өгч, шимтгэлийн урсгал болон хуримтлагдсан авлага үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагуудтай шат дараалсан арга хэмжээг авах ажлыг зохион байгуулсан бөгөөд Нийслэлийн нийгмийн даатгалын газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэстэй хамтран нийслэлийн 6 дүүрэгт баг болон ажилласан. Энэ хугацаанд 286 аж ахуйн нэгжийн зарлагын

гүйлгээний дансыг хааж, улсын байцаагчийн албан шаардлага 232, график байгуулсан 192, шүүхэд шилжүүлсэн 3 нийт 713 аж ахуйн нэгжид шат дараалсан арга хэмжээ авсан байна. Аяны хүрээнд нийт 622 аж ахуйн нэгж, байгууллагын 30,8 тэрбум төгрөгийн урсгал болон хуримтлагдсан авалгаас барагдуулж ажилласан байна.

Гурав. Хэлтсийн дотоод ажлын талаар

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны зардлын 2022 оны эхний хагас жилд батлагдсан төсвийн 524 687 700 төгрөгийн үйл ажиллагааны урсгал санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зардлын төрлөөр зарцуулан ажилласан.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэл, зарлага, өр авлагын дэлгэрэнгүй мэдээг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, ахлах нягтлан бодогч-ахлах мэргэжилтнээр хянуулж, хэлтсийн дарга болон газрын даргад танилцуулж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1-12 сарынаж ахуй материал, бичиг хэрэг, шатах тослох материалын зардлын тооцоог холбогдох байгууллага ажилтантай тооцоо хийж, анхан шатны баримтыг үндэслэн тайланг цаг тухайд нь гарган ажиллаж байна.

2021 оны жилийн эцэс, 2022 оны 1-11 дүгээр сарын нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн тайланг гаргаж Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд тайлагнасан.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс тогтоосон хуваарийн дагуу батлагдсан маягтаар дүүрэг тус бүрээр хүлээн авч хянаж, шалган нэгтгэж, тайлбар танилцуулгын хамт газрын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бодлогын хэрэгжилт, судалгааны газарт 2022 оны 07 дугаар сарын 5-ны өдөр хүргүүлсэн.

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын бүтэц орон тоо, норм нормативыг шинэчлэн батлахтай холбогдуулан тоон мэдээ судалгааг (нийт ажил олгогч, албан журмын даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо сайн дурын даатгуулагчийн тоо, эрүүл мэндийн даатгалд хамрагдсдын тоо, хүн амын тоо) сүүлийн 3 жилийн байдлаар гарган газрын удирдлагад танилцуулсан.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 25-ны А/30 тоот “Үндсэн хөрөнгө тооллого явуулах тухай” тушаалаар хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллого мөн ННДГ-ын даргын 2022 оны 12 дугаар 08-ны өдрийн А/41 тушаалаар жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллого хийж тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгөгүй, хадгалалт хамгаалалт их бүрэн, шинээр хүлээн авсан хөрөнгүүдийг кодолж, ажилтнуудын эд хөрөнгийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.

Тус газрын 2021 оны үндсэн хөрөнгийн бүртгэлийг burtgel.pcsp.gov.mn программд нэг бүрчлэн бүртгэж, биелэлтийг нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.

Санхүү бүртгэлийн хэлтэс нь 2021 оны нэгтгэсэн санхүүгийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын сан, үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны харилцахын баримт, аж ахуй, бичиг хэрэг, шатахуун, сэлбэг хэрэгслийн тайлангуудыг нэгтгэж нийт 61 боть баримтыг архивын нэгж бүрдүүлэн архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгч, архивын нэгж бүрдүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын мэдээллийн системийн шинэчлэлийн хүрээнд нийгмийн даатгалын программ хангамжуудыг нэгтгэн вэб технологид буюу бодит цагийн горим (рийл тайм)-д хугацааны алдагдалгүй ажиллах хөгжүүлэлт хийж байна. Системийг шинэчлэн хөгжүүлэх ажлыг Азийн хөгжлийн банкны “Хүнс тэжээл, нийгмийн хамгааллын нэмэлт санхүүжилт” төслийн санхүүжилтээр Ай Ти Зон ХХК хариуцан гүйцэтгэж эхний шатанд байгууллагын санхүү болон хүний нөөцийн системийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс салбарын хэмжээнд нэвтрүүлсэн.

Green Finance системийн Green ERP программыг ашиглаж байгууллагын нягтлан бодох бүртгэлээ хөтөлж, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2022 оноос сар бүр төсвийн гүйцэтгэл, сарын мэдээ болон 2022 оны улирлын болон жилийн эцсийн тайланг гарган ажилласан.

Дөрөв. Газрын үйл ажиллагаатай холбоотой хийсэн ажил:

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 7 хоног бүрийн Баасан гарагт зохион байгуулдаг Мэдээллийн цаг хөтөлбөрт тухай бүр хамрагдсан.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, цахим шилжилтийн бодлого зорилттой уялдуулан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төрийн сангийн цахимжуулалтын үе шаттайгаар нэвтрүүлж байгаатай холбоотойгоор 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан төсөвт байгууллагын цалингийн нэгдсэн системийн гүйлгээг эрхийн бүртгэлийн сан системийг ашиглан цахимаар баталгаажуулах сургалтад тус газрын дарга, ахлах нягтлан бодогч-ахлах мэргэжилтэн хамрагдаж, тус газрын ажилтан, албан хаагчдын цалинг байгууллагын дарга, ахлах нягтлан бодогчийн гарын үсгийг цахимаар баталгаажуулж олгож байна.

2022 оны 11 дугаар сарын 4-ны өдрийн Нийслэлийн засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарын баталсан хөтөлбөрийн дагуу Санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэхэд санхүүгийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх сургалтанд хамрагдсан.

Япон улсын жайка төслийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 11 дүгээр сарын 18-ны хооронд хэлтсийн дарга С.Ундармаа, ахлах нягтлан бодогч-ахлах мэргэжилтэн М.Цандмаа нар Монгол улсын Нийгмийн даатгалын салбар дахь санхүүгийн шинжилгээний практик ур чадварын бэхжүүлэх сургалтанд онлайн ажилттай оролцож суралцсан.

“Санхүүгийн албан хаагчдыг мэдлэг ур чадварыг дээшлүүлэх” сургалт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

1.1 ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

1.1.1. 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлагдсан 01 тоот удирдамжийн дагуу тус хэлтсийн байцаагч нар 3 багт хуваагдан “Тэтгэвэр олголтын хяналтын програм”-д тусгагдсан нас барснаас хойш тэтгэвэр илүү олгосон, давхар тэтгэвэр авдаг, тэтгэврийн нас буруу, харъяатаас гарсан гэсэн 4 үзүүлэлтээр 2021 оны 01-12 сарыг хамруулан 2022 оны 01 дүгээр сарын 05-наас 02 дугаар сарын 07-ны хооронд мэдээллийн баазад тулгуурлан цахим хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Нийслэлийн хэмжээнд нийт давхар тэтгэвэр авдаг 70,893 тохиолдлоос өөр төрлийн тэтгэвэр давхар авдаг ба өндөр насны тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэвэр давхар авдаг тэтгэвэр авагчдыг шүүлт хийн хасч, зөвхөн нэг төрлийн тэтгэвэр давхардуулан авч байгаа эрсдэлтэй байх магадлалтай тэтгэвэр авагчдын 35 мэдээллийг түүвэрлэн авч даатгуулагчийн тэтгэврийн олголтод цахимаар хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар 4 аймаг, 3 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст програмд тэтгэвэр авагчийг давхар бүртгэсэн, шилжиж явсан хөдөлгөөн хийгээгүй, тахир дутуугийн тэтгэвэрт зогсоох хөдөлгөөн хийгээгүй шалтгаанаар нийт 9 тэтгэвэр авагчид 10,9 сая төгрөгийн тэтгэвэр давхардуулан олгосон зөрчил илрүүлж, улсын байцаагчийн акт тогтоосон.

Шалгалтын мөрөөр дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст зөрчлийг бүрэн барагдуулах, дотоодын хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлж алдаа дутагдалгүй ажиллах “Зөвлөмж” хүргүүлж ажилласан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн барагдуулж ажилласан.

1.1.2. 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан 02 тоот удирдамжийн дагуу Хан-уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн 2020 онд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байдалтай танилцан, судалгаа шинжилгээ хийж, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллалаа.

Шалгалтын хүрээнд Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн 2020 онд шийдвэрлэсэн 89 боть, 415 зөрчлийн материалтай танилцлаа.

Шалгалтад хамрагдсан дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүд Зөрчлийн тухай хуулийн 10.17.1, 10.17.2, 10.17.3, 10.17.4, 10.17.5 дугаар заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар хялбаршуулсан журмаар 330 аж ахуйн нэгж, байгууллагад 115,6 сая төгрөгийн торгууль ногдуулж, 85 материалд зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Шалгалтаар:

1. Зөрчлийн тухай хуулийн заалтуудыг хооронд нь хольж сольж, андуурч хэрэглэсэн;
2. 50 зөрчлийн материалд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтад хамаарах торгуулиас 14,3 сая төгрөгийн илүү, 37 сая төгрөгийн дутуу торгууль оногдуулсан;
3. 45 зөрчлийн материалд цалин хөлс олгосон болон бусад холбогдох санхүүгийн нотлох баримтыг хавсаргаагүй;

4. 15 зөрчлийн материалыг хөөн хэлэлцэх хугацаа дууссан байхад зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн;
5. 27 зөрчлийн материалд Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, Нийгмийн даатгалын хуулийн заалтаар улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэсэн;
6. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан зөрчилд зөрчлийн хэрэг нээж шимтгэл нөхөн төлүүлсэн болон зөрчлийн материалд санхүүгийн нотлох баримт хангалтгүй бүрдүүлж нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан нөхөж авснаар 16 иргэнд 36,2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авах боломжийг бүрдүүлсэн зэрэг зөрчил илэрсэн бөгөөд Хөөн хэлэлцэх хугацаа дууссан зөрчилд зөрчлийн хэрэг нээж шимтгэл нөхөн төлүүлсэн болон зөрчлийн материалд санхүүгийн нотлох баримт хангалтгүй бүрдүүлж нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан нөхөж авснаар 16 иргэнд 36,2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авах боломжийг бүрдүүлсэн зэрэг зөрчил илэрсэн. Шалгалтын мөрөөр дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд зөрчлийг давтан гаргахгүй байх Зөвлөмж хүргүүлсэн бөгөөд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, хуулийн талаар нэг мөр ойлголттой болох зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Прокурорын газартай хамтран сургалт, семинар зохион байгуулав.

1.1.3. 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан 03 тоот удирдамжийн дагуу дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн “Малчин” нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоосон өндөр насны тэтгэврийн үндэслэлийг шалгах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ныг хүртэлх ажлын 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн “Малчин” нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нийт 631 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, анхан шатны баримтад тулгуурлан шалгав.

Мөн тэтгэвэр авагчдын тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг болон “мал тэжээвэр амьтад, малын хашаа худгийн ...оны тооллого”-н жил бүрийн бүртгэл “А” дансны архивын лавлагаа, малчин өрхийн гишүүний бүртгэлийн хуулбар болон 1995 оноос хойших хугацаанд мал маллаж байсныг нотлох аймаг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн тогтоол, шимтгэл төлсөн хугацаа зэрэг холбогдох баримт материалын үндэслэлийг шалгаж, баталгаажууллаа.

Шалгалтаар НДСОТТТ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7.1-д заасан ажилласан жилийн болзлыг хангаагүй 1 иргэнд холбогдох 0,8 сая төгрөгийн, шүүхэд хуурамч материал /архивын лавлагаа/ бүрдүүлэн өгч малчнаар ажилласан жил тогтоолгосон 3 иргэнд холбогдох 39,9 сая төгрөгийн, 1995 оноос хойш малчнаар ажилласан хугацааг тодорхойлох орон тооны бус зөвлөлийн тогтоол үндэслэлгүй 3 иргэнд холбогдох 23,6 сая төгрөгийн нийт 6 иргэнд холбогдох 63,5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн.

Зөрчил гаргасан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд төлбөр зөрчлийг барагдуулах хугацаатай үүрэг өгч ажилласан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 иргэнтэй холбогдох асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 3 иргэнтэй холбогдох зөрчилд үндэслэлгүй олгосон тэтгэврийг нөхөн төлүүлэх улсын байцаагчийн акт тогтоон ажиллав.

1.1.4. 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан 04 тоот удирдамжийн дагуу Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн

тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, зардлын зарцуулалт, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, тушаал шийдвэр, албан хэргийн хөтлөлтийн стандартын хэрэгжилт, ажилгүйдлийн болон ХЧТА, ЖА, оршуулгын тэтгэмжийн бодолт олголт, санхүүгийн тайланд тусгасан тодорхойгүй өглөг авлагын бүртгэл тайлагналт, дотоодын хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, үр дүн, шимтгэлийн тайлан авалт, даатгуулагчийн мэдээлэл засварлалт, өр авлага барагдуулалт, архивын мэдээллийг боловсруулах, ашиглахтай холбогдсон харилцааг 2020, 2021 оныг хамруулан 2022 оны 05 дугаар сарын 09-нөөс 11-ний хооронд шалгалаа.

Тус хэлтэст 2020, 2021 оны ААНБ-ын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт төлөлтийн НД№7, НД№8 тайланг шимтгэлийн цахим програм, нийгмийн даатгалын лавлагааны програмтай тулган шалгахад ажил мэргэжлийн ангилал буруу бүртгэсэн, даатгуулагчийн төрөл код буруу тайлагнасан, хугацаа хоцроосон шимтгэлийн тайланг авахдаа “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах журам”-ыг зөрчиж санхүүгийн анхан шатны нотлох баримтыг бүрдүүлээгүй, торгууль шийтгэврийн хуудсаар торгууль ногдуулаагүй, даатгуулагчийн үндсэн мэдээлэл, регистрийн дугаарыг нэгтгэх болон шинэчлэхдээ зохих нотлох баримт, анхан шатны баримтын бүрдүүлбэрийг бүрэн хангаагүй, эсвэл огт бүрдүүлээгүй, архивын нэгж үүсгээгүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зөрчил гараагүй тул хяналт шалгалтын ажлын хүрээнд гаргасан Зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаа.

1.1.5. Батлагдсан удирдамжийн дагуу Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, тушаал шийдвэр, албан хэргийн хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг 2018-2021 оныг дуустал хугацааг хамруулан 2022 оны 05 дугаар сарын 23-наас 06 сарын 03-ны хооронд шалгалаа.

Шалгалтаар нийт 2 хүнд холбогдох 1,0 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснийг шалгалтын хугацаанд 100 хувь бүрэн барагдуулж, гаргасан зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлж алдаа дутагдалгүй ажиллах “Зөвлөмж” хүргүүлж ажиллав.

1.1.6. Батлагдсан удирдамжийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд Нийслэлийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд нийгмийн даатгалын цахим хяналт шалгалт /monitoring/ -н програмыг тулгуурлан Нийгмийн даатгалын тухай хууль, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын хэрэгжилтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацааг хамруулан шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

Шалгалтаар Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч нар “Номин карт” ХХК, “Наран смарт” ХХК, “Г энд М старс” ХХК-иудад нотлох баримт хангалтгүйгээр улсын байцаагчийн акт тогтоон шимтгэл нөхөн төлүүлсэн, орлого шимтгэлийн байцаагч нар “Бүтээлч шинэ сонголт” ХХК, “Билиг сургаал нийгэмлэг”, “БНБ төлөө иргэний нийгмийн эвсэл”, “Бигүхан” ХХК-иудаас анхан шатны нотлох баримтгүйгээр нөхөн тайлан авсан зөрчил илэрсэн. Мөн Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн орлого шимтгэл бүрдүүлэлтийн тасгийн дарга нь “Хероесвин” ХХК-ий даатгуулагч Гүрбазар овогтой Балжинням /ИИ64101011/-ын цалинг засварлахдаа “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ыг зөрчиж, хяналтын картыг өөрөө үйлдэж, хянуулахгүйгээр цалин засварласан зөрчил илэрсэн. Зөрчил гаргасан нийгмийн даатгалын

хэлтсүүдэд зөрчлийг арилгах, зөрчил давтан гаргахгүй байхад чиглэсэн зөвлөмж хүргүүлж, биелэлтийг ханган ажиллав.

1.2. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

1.2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр баталсан удирдамжийн дагуу НДЕГ-ын ХШГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг шалгалаа. Шалгалтаар хуурамч баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 64 иргэнд холбогдох 1612,4 сая төгрөгийн, НДСОТТТ хуулийг зөрчиж 65 хүнд 54,4 сая төгрөг илүү олгосон, 42 хүнд 43,6 сая төгрөг дутуу олгосон, бүрдэл дутуу баримтаар 54 хүнд тэтгэвэр тогтоож олгосон, мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 27 даатгуулагчдад 17,1 сая төгрөгийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай НДЕГ-ын А/133 дугаар тушаал хүргүүлэн, биелэлтийг хангуулж ажиллав. 2022 оны жилийн эцсийн байдлаар шалгалтаар илэрсэн зөрчлийн 50 хувийг барагдуулж ажилласан.

1.2.2. Батлагдсан удирдамжийн дагуу Санхүү бүртгэлийн хэлтэстэй хамтран Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомж, дүрэм журам зааврын хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудал, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, хэлтсийн удирдлага, байцаагч ажилтнуудад чиглэл өгч, шимтгэлийн урсгал болон хуримтлагдсан авлага үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, зохих журмын дагуу шат дараалсан арга хэмжээг авах ажлыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс шимтгэлийн авлага барагдуулах аян зохион байгуулж, дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн орлого шимтгэлийн тасагт ажиллаа. Аяны хүрээнд 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 64,4 тэрбум төгрөгийн шимтгэлийн өртэй 622 ажил олгогч байгууллагын эрх бүхий албан тушаалтантай уулзалт ярилцлага хийж 22,8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өр авлагыг барагдуулж ажилласан. Мөн хуримтлагдсан өртэй 286 ААНБ-н арилжааны банк дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 232 ААНБ-д албан шаардлага хүргүүлж, 3 ААНБ-ыг шүүхэд шилжүүлэн, 192 ААНБ-тай өр барагдуулах гэрээ байгуулан, график байгуулж ажиллаа.

ХОЁР. ГАДААД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу гадагшаа чиглэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг зогсоосон. Харин иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд нийт 797 ААНБ-д Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж нийт 771 аж ахуйн нэгж, байгууллагад 647,8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 26 аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан тухай “Танилцуулга” хүргүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт илэрсэн төлбөр зөрчлийн 616,2 сая төгрөг буюу 95 хувийг барагдуулж ажилласан байна.

ГУРАВ. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтны судалгааг гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болон Нийслэлийн Прокурорын газарт хүргүүлэн ажилласан.

Нийслэлийн хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 469 аж ахуйн нэгж, байгууллагад 155,0 сая төгрөгийн торгууль оногдуулж, торгуулийн төлбөрийг бүрэн барагдуулж ажилласан байна.

Дүүрэг тус бүрээр хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэлтсийн нэр	Шалгасан аж ахуйн нэгж байгууллагын тоо	Торгуулийн дүн	Барагдуулалт
1.	Баянгол дүүрэг НДХ	94	26.750.000	26.750.000
2.	Баянзүрх дүүрэг НДХ	97	24.200.000	24.200.000
3.	Сонгинохайрхан дүүрэг НДХ	38	19.750.000	19.750.000
4.	Сүхбаатар дүүрэг НДХ	151	59.250.000	59.250.000
5.	Хан-Уул дүүрэг НДХ	46	12.300.000	12.300.000
6.	Чингэлтэй дүүрэг НДХ	27	9.250.000	9.250.000
7.	Налайх дүүрэг НДХ	11	2.300.000	2.300.000
8.	Багахангай дүүрэг НДХ	5	1.200.000	1.200.000
9.	Багануур дүүрэг НДХ	0	0	0
Нийт		469	155.000.000	155.000.000

ДӨРӨВ. ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн Цахим хяналтын систем”-(<http://10.9.0.5/monitoring>) хяналт шалгалтын програмаар хяналт шалгалт хийж байгаа байдалд хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

2022 оны жилийн эцсийн байдлаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн цахим хяналт шалгалтын “Мониторинг” програм ашиглалтын дундаж хувь 86,7 байна.

Дүүрэг тус бүрээр харуулбал:

Д/д	Хэлтсийн нэр	Хувь
1.	Сүхбаатар	75
2.	Багахангай	100
3.	Хан-Уул	95
4.	Налайх	93
5.	Сонгинохайрхан	50
6.	Багануур	100
7.	Баянгол	91
8.	Баянзүрх	85
9.	Чингэлтэй	92
Дундаж хувь		86,7

ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН, МЭДЭЭ АВАЛТЫН ТАЛААР

Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн дотоодын хяналт, шалгалт болон дээд газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ тайланг шалган хүлээн авч нэгтгэн, баталгаажуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлж ажиллав.

2022 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд хяналт, шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчлийн 92,8 хувийг барагдуулж ажилласан байна. Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэст хуримтлагдсан өр авлага барагдуулах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

№	Дүүргийн нэр	Улсын байцаагчийн актаар тогтоогдсон нийт төлбөр, зөрчлийн барагдуулалт /сая төгрөг/			
		Оны эхний үлдэгдэл	Илрүүлсэн дүн	Барагдуулалт	Үлдэгдэл
1.	Налайх	15.8	48.4	50.4	13.8
2.	Баянгол	430.1	431.7	382.1	479.6
3.	Багануур	101.6	45.0	22.2	124.4
4.	Багахангай	7.2	18.8	14.9	11.0
5.	Хан-Уул	390.1	153.1	153.02	390.1
6.	Сонгинохайрхан	47,02	334.1	263.2	117.9
7.	Сүхбаатар	258.3	283.5	209.4	332.3
8.	Чингэлтэй	101.9	167.9	193.3	76.8
9.	Баянзүрх	867.8	5794.0	5486.0	1175.8
Нийт дүн		2,219.8	7,276.5	6,774.5	2,721.7

ЗУРГАА . ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР

6.1. Төсвийн ерөнхийлөн захирагч /Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч/-аас төсвийн шууд захирагч /Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дарга/-тай байгуулсан Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Нийслэлийн нийгмийн даатгалын даргын 2022 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг:

- Төсвийн шууд захирагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө;
- Үйл ажиллагаа, санхүү, бусад тайлан, мэдээнүүд
- Тушаал шийдвэр, хугацаатай баримт, бичгийн биелэлтийн тайлан;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ /улирал бүрийн/;
- Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлсэн эсэхэд тулгуурлан арга хэмжээ, ажил үйлчилгээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэв.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Нийслэлийн төсвийн шууд захирагч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг хагас жилийн байдлаар зохих түвшинд биелүүлсэн тул Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 97.7 хувь буюу **Хангалттай** гэж үнэлж дүгнэлээ.

Д/д	Ажил үйлчилгээ	Өгвөл зохих оноо	Хэрэгжилтийн хувь
1.	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах.	0-100	96
2.	Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд хяналт тавьж ажиллах.	0-100	100
3.	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.	0-100	100
4.	Төрийн мэдээлэл солилцсон “ХУР” системийг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.	0-100	90
5.	Нэг цонхны үйлчилгээний эрх зүйг орчинг бүрдүүлнэ.	0-100	100
6.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах.	0-100	100
Нийт оноо			97,7

Нийслэлийн төсвийн шууд захирагч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг хагас жилийн байдлаар зохих түвшинд биелүүлсэн тул Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 97.7 хувь буюу **Хангалттай** гэж үнэлж дүгнэлээ.

6.2. 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 206 тоот тогтоолын дагуу Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтэд үнэлгээ, хяналт-шинжилгээ хийв.

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль -3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг -1, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар -1, Засгийн газрын тогтоол -12, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -7, Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал 5, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайдын албан даалгавар -1, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол -3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал -15, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар -1 нийт 49 тогтоол, шийдвэрийн заалтыг хяналтад авсан байна.

Хяналтад авсан 49 тогтоол шийдвэрийн хэрэгжиж буй заалтуудын 40 бүрэн биелэгдсэн буюу 100 хувьтай үнэлэгдэв.

Монгол Улсын хууль -3 бүрэн хэрэгжсэн 100 хувьтай,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг -1, 80 хувьтай,

Монгол Улсын ерөнхий сайдын албан даалгавар -1, 100 хувьтай

Засгийн газрын -9 тогтоол шийдвэр бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, -1 тогтоол 90 хувьтай, -1 тогтоол 95 хувьтай, -1 тогтоол 99 хувьтай хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -7, бүрэн хэрэгжсэн -6, 1 тэмдэглэл 80 хувийн хэрэгжилттэй байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын -5 тушаал бүрэн хэрэгжиж биелэлт 100 хувьтай;

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын -1 албан даалгаврын биелэлт 100 хувьтай

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн -3 тогтоол бүрэн хэрэгжиж 100 биелэлтэй

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын -15 тушаалаас -13 тушаал бүрэн хэрэгжсэн биелэлт 100 хувьтай, -2 тушаал 90 хувийн биелэлттэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын -1 албан даалгавар бүрэн хэрэгжиж 100 хувьтай байна. Нийт дундаж 97,4 хувиар үнэлэлт өгсөн байна.

6.3. 2022 оны жилийн эцсийн байдлаар тус газарт хандаж ирүүлсэн, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн байдалд шинжилгээ-үнэлгээ хийлээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар ННДГ-т 232 өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэл хөтөлж, удирдалагад танилцуулж ажилласан байна.

Өргөдөл, гомдол, санал, талархал, хүсэлт /хэлбэрээр/

№	Нийт өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
		1800-1200 тусгай дугаарын утас	Гар утасны аппликейш наар	Засгийн газрын 11-11 төв	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	Нутгийн захиргааны байгууллагууд
1	232	37	13	114	2	66

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Нийт өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Шийдвэрлэх шатандаа байгаа	
1	232	229	578	9	3	98,7%

Өргөдөл гомдлыг хэлбэрээр нь ангилбал:

1. Талархал-3 буюу 1,3 %
2. Гомдол-137 буюу 59,1 %
3. Санал-10 буюу 4,3 %
4. Хүсэлт-82 буюу 35,3 %

Гомдол нь нийт өргөдөл гомдлын 59,1 хувийг эзэлж байна. Гомдлын ихэнх хувь нь нийгмийн даатгалын байгууллага, байцаагч, албан тушаалтны харилцаа, ёс зүйтэй холбоотой, мөн нийгмийн даатгалын байгууллага утсаа авдаггүй, хүнд сурталтай, сэтгэл ханамжид нийцсэн зөвлөгөө, мэдээлэл өгдөггүй гэсэн агуулгатай байна.

Тус газарт ирүүлсэн 232 өргөдөл гомдол, хүсэлтээс 229 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж бөгөөд шийдвэрлэлт 98,7 хувьтай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 17 цаг 14 минут байгаа нь зорилтод түвшиндээ хүрсэн гэж дүгнэв. Харин 9 өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэнд анхаарч, цаашид зөрчил гаргахгүй ажиллах шаардлагатай байна.

Нийт өргөдөл гомдлын ихэнх хувийг гомдол эзэлж, мөн иргэд даатгуулагчдаас ирүүлсэн талархал 3 байгаа нь үйл ажиллагаагаа сайжруулах, байцаагч ажилтнуудын харилцаа, ёс зүйд анхаарч ажиллах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ хийснээр гомдлын тоог бууруулах, санал хүсэлт, талархлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан.

6.4. Газрын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт болон шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж буй байдалд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Газрын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд 6 хэрэглэгчээр, 3 цэсний төсөв гүйцэтгэл-9, хөрөнгө оруулалт-5, бусад-7 нийт 21 төрлийн мэдээлэл байршуулсан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл 100 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдэв. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлагыг сайжруулах тухай санал хүргүүлж ажиллав.

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР